



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



“АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨҮГ

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН СУДАЛГАА - II



21 АЙМГИЙН НУТГИЙН ИРГЭДИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТАЛААРХ МЭДЛЭГ, ОЙЛГОЛТЫН СУДАЛГАА

УЛААНБААТАР ХОТ
2021 ОН



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



“АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨҮГ

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН СУДАЛГАА - II

***21 аймгийн нутгийн иргэдийн аялал жуулчлалын
талаарх мэдлэг, ойлголтын судалгаа***

УЛААНБААТАР ХОТ
2021 ОН

ТАЛАРХАЛ

УГ СУДАЛГААНЫ АЖИЛД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛСЭН 21 АЙМГИЙН БАЙГАЛЬ
ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭНҮҮДЭД
ТАЛАРХАЛ ИЛЭРХИЙЛЭЕ.

Г.Батцэцэг, Х.Даут, Д.Содномсамдан, Д.Болормаа, М.Алтанцэцэг, Б.Гансүх,
Н.Солонго, У.Зулгэрэл, С.Энхзориг, Б.Ганзориг, Б.Батхүү, Б.Пүрэвжаргал,
Д.Осоржамаа, П.Ариунболд, М.Мөнхсүрэн, Н.Хуяг, Д.Батзаяа, Н.Нямбат,
Б.Мөнхдолгор, Д.Дуламсүрэн, Б.Амартүвшин, Б.Баясгалан, Н.Бурмаа.

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН СУДАЛГАА - II

**ИРГЭДИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТАЛААРХ МЭДЛЭГ,
ОЙЛГОЛТЫГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГАА**

Судалгааны багийн бүрэлдэхүүн:

Багийн зөвлөх

М.БИЛЭГСАЙХАН /PhD/
Худалдаа Үйлдвэрлэлийн Их Сургууль,
Худалдаа, маркетингийн тэнхимийн дэд профессор, судлаач

Гишүүн

С.АМАРЖАРГАЛ /PhD/
Худалдаа Үйлдвэрлэлийн Их Сургууль,
Худалдаа, маркетингийн тэнхимийн ахлах багш, судлаач

Б.ХАЛИУН /МВА/
Судалгааны туслах ажилтан
Худалдаа Үйлдвэрлэлийн Их Сургууль, магистрант

Захиалагч:

Аялал жуулчлалын хөгжлийн төв, ААТТӨҮГ

АГУУЛГА

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ.....	v
ЗУРГИЙН ЖАГСААЛТ.....	xi

БҮЛЭГ 1. УДИРТГАЛ

1.1 Судалгааны зорилго, зорилт.....	1
1.2 Судалгааны үндэслэл.....	2
1.3 Судалгааны нэр томъёоны тодорхойлолт.....	5

БҮЛЭГ 2. СУДАЛГААНЫ АРГАЗҮЙ

2.1 Түүвэрлэлт.....	7
2.2 Өгөгдөл цуглуулалт.....	8
2.3 Судалгааны аргачлал.....	10

БҮЛЭГ 3. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

3.1 Судалгаанд оролцогчдын талаархи мэдээлэл.....	11
3.2 Аялал жуулчлалын нөлөөллийн үнэлгээ.....	13
3.3 Судалгааны найдвартай ба үндэслэлтэй байдал.....	19
3.4 Аялал жуулчлалын эерэг ба сөрөг нөлөөллийн тухай ойлголтын зөрүү.....	24
3.5 Аялал жуулчлалын өөрчлөлтүүдийн хоорондын хамаарал.....	25
3.6 Дүгнэлт.....	25
3.7 Зөвлөмж.....	30

БҮЛЭГ 4. АЙМГУУДЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮНГИЙН НЭГТГЭЛ, ЗӨВЛӨМЖ

4.1 Архангай аймаг.....	34
4.2 Баян-Өлгий аймаг.....	37
4.3 Баянхонгор аймаг.....	41
4.4 Булган аймаг.....	45
4.5 Говь-Алтай аймаг.....	48
4.6 Говьсүмбэр аймаг.....	52
4.7 Дархан-Уул аймаг.....	55
4.8 Дорноговь аймаг.....	59

4.9 Дорнод аймаг.....	63
4.10 Дундговь аймаг	66
4.11 Завхан аймаг	70
4.12 Орхон аймаг	73
4.13 Өвөрхангай аймаг	77
4.14 Өмнөговь аймаг.....	81
4.15 Сүхбаатар аймаг.....	85
4.16 Сэлэнгэ аймаг	89
4.17 Төв аймаг	93
4.18 Увс аймаг	96
4.19 Ховд аймаг	100
4.20 Хөвсгөл аймаг	104
4.21 Хэнтий аймаг	107

БҮЛЭГ 5. АШИГЛАСАН МАТЕРИАЛ, ӨГӨГДЛИЙН ЖАГСААЛТ

5.1 Ном зүй.....	112
5.2 Хавсралт (Аймаг тус бүрийн дэлгэрэнгүй үзүүлэлт)	
5.2.1 Архангай аймаг	115
5.2.2 Баян-Өлгий аймаг	119
5.2.3 Баянхонгор аймаг.....	123
5.2.4 Булган аймаг	127
5.2.5 Говь-Алтай аймаг.....	131
5.2.6 Говьсүмбэр аймаг	135
5.2.7 Дархан-Уул аймаг	139
5.2.8 Дорноговь аймаг	143
5.2.9 Дорнод аймаг.....	147
5.2.10 Дундговь аймаг.....	151
5.2.11 Завхан аймаг	155
5.2.12 Орхон аймаг	159
5.2.13 Өвөрхангай аймаг	163
5.2.14 Өмнөговь аймаг.....	167
5.2.15 Сүхбаатар аймаг.....	171
5.2.16 Сэлэнгэ аймаг	175
5.2.17 Төв аймаг	179
5.2.18 Увс аймаг	183
5.2.19 Ховд аймаг	187
5.2.20 Хөвсгөл аймаг	191
5.2.21 Хэнтий аймаг	195
5.3 Судалгааны асуулга (хэвлэмэл эх загвар).....	199

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Түүврийн хэмжээ (бүх аймгаар).....	7
Хүснэгт 2. Аймгуудаас ирүүлсэн шаардлага хангасан асуулгын тоон үзүүлэлт (бүх аймгаар)	9
Хүснэгт 3. Судалгаанд хамрагдсан хүмүүсийн ерөнхий мэдээлэл (бүх аймгаар)	11
Хүснэгт 4. Хөдөлмөр эрхлэлт ба аялал жуулчлалын үйл ажиллагааны хамаарал (бүх аймгаар)	13
Хүснэгт 5. Аялал жуулчлалын нөлөөллийн үнэлгээний түвшин (бүх аймгаар)	14
Хүснэгт 6. Хүчин зүйлийн шинжилгээний үр дүн болон найдвартай байдлын шинжилгээ (бүх аймгаар)	20
Хүснэгт 7. Хоёр үл хамаарсан түүврийн т шалгуурын үр дүн (бүх аймгаар)	24
Хүснэгт 8. Корреляцийн шинжилгээний үр дүн (бүх аймгаар)	25
Хүснэгт 9. Зөвлөмж боловсруулах матриц	30
Хүснэгт 10. ЗӨВЛӨМЖ: Архангай аймаг	35
Хүснэгт 11. ЗӨВЛӨМЖ: Баян-Өлгий аймаг	39
Хүснэгт 12. ЗӨВЛӨМЖ: Баянхонгор аймаг	42
Хүснэгт 13. ЗӨВЛӨМЖ: Булган аймаг	46
Хүснэгт 14. ЗӨВЛӨМЖ: Говь-Алтай аймаг	50
Хүснэгт 15. ЗӨВЛӨМЖ: Говьсүмбэр аймаг	53
Хүснэгт 16. ЗӨВЛӨМЖ: Дархан-Уул аймаг	57
Хүснэгт 17. ЗӨВЛӨМЖ: Дорноговь аймаг	60
Хүснэгт 18. ЗӨВЛӨМЖ: Дорнод аймаг	64
Хүснэгт 19. ЗӨВЛӨМЖ: Дундговь аймаг	68
Хүснэгт 20. ЗӨВЛӨМЖ: Завхан аймаг	71
Хүснэгт 21. ЗӨВЛӨМЖ: Орхон аймаг	75
Хүснэгт 22. ЗӨВЛӨМЖ: Өвөрхангай аймаг	78
Хүснэгт 23. ЗӨВЛӨМЖ: Өмнөговь аймаг	82
Хүснэгт 24. ЗӨВЛӨМЖ: Сүхбаатар аймаг	86
Хүснэгт 25. ЗӨВЛӨМЖ: Сэлэнгэ аймаг	90



Хүснэгт 26. ЗӨВЛӨМЖ: Төв аймаг	94
Хүснэгт 27. ЗӨВЛӨМЖ: Увс аймаг	98
Хүснэгт 28. ЗӨВЛӨМЖ: Ховд аймаг	101
Хүснэгт 29. ЗӨВЛӨМЖ: Хөвсгөл аймаг	105
Хүснэгт 30. ЗӨВЛӨМЖ: Хэнтий аймаг	109
Хүснэгт 31. Судалгаанд оролцогчдын талаархи мэдээлэл	115
Хүснэгт 32. Аялал жуулчлалын нөлөөллийн үнэлгээ	115
Хүснэгт 33. Аялал жуулчлалын эерэг ба сөрөг нөлөөллийн тухай ойлголтын зөрүү	118
Хүснэгт 34. Аялал жуулчлалын өөрчлөлтүүдийн хоорондын хамаарал....	118
Хүснэгт 35. Баян-Өлгий аймгийн судалгаанд оролцогчдын талаархи мэдээлэл.....	119
Хүснэгт 36. Баян-Өлгий аймгийн иргэдээс өгсөн аялал жуулчлалын нөлөөллийн үнэлгээ	119
Хүснэгт 37. Баян-Өлгий аймгийн иргэдийн аялал жуулчлалын эерэг ба сөрөг нөлөөллийн тухай ойлголтын зөрүү	122
Хүснэгт 38. Баян-Өлгий аймгийн аялал жуулчлалын өөрчлөлтүүдийн хоорондын хамаарал	122
Хүснэгт 39. Баянхонгор аймгийн судалгаанд оролцогчдын талаархи мэдээлэл.....	123
Хүснэгт 40. Баянхонгор аймгийн иргэдээс өгсөн аялал жуулчлалын нөлөөллийн үнэлгээ	123
Хүснэгт 41. Баянхонгор аймгийн иргэдийн аялал жуулчлалын эерэг ба сөрөг нөлөөллийн тухай ойлголтын зөрүү	126
Хүснэгт 42. Баянхонгор аймгийн аялал жуулчлалын өөрчлөлтүүдийн хоорондын хамаарал	126
Хүснэгт 43. Булган аймгийн судалгаанд оролцогчдын талаархи мэдээлэл.....	127
Хүснэгт 44. Булган аймгийн иргэдээс өгсөн аялал жуулчлалын нөлөөллийн үнэлгээ.....	127
Хүснэгт 45. Булган аймгийн иргэдийн аялал жуулчлалын эерэг ба сөрөг нөлөөллийн тухай ойлголтын зөрүү	130
Хүснэгт 46. Булган аймгийн аялал жуулчлалын өөрчлөлтүүдийн хоорондын хамаарал	130
Хүснэгт 47. Говь-Алтай аймгийн судалгаанд оролцогчдын талаархи мэдээлэл.....	131
Хүснэгт 48. Говь-Алтай аймгийн иргэдээс өгсөн аялал жуулчлалын нөлөөллийн үнэлгээ	131

Хүснэгт 49. Говь-Алтай аймгийн иргэдийн аялал жуулчлалын эерэг ба сөрөг нөлөөллийн тухай ойлголтын зөрүү	134
Хүснэгт 50. Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын өөрчлөлтүүдийн хоорондын хамаарал	134
Хүснэгт 51. Говьсүмбэр аймгийн судалгаанд оролцогчдын талаархи мэдээлэл.....	135
Хүснэгт 52. Говьсүмбэр аймгийн иргэдээс өгсөн аялал жуулчлалын нөлөөллийн үнэлгээ	135
Хүснэгт 53. Говьсүмбэр аймгийн иргэдийн аялал жуулчлалын эерэг ба сөрөг нөлөөллийн тухай ойлголтын зөрүү	138
Хүснэгт 54. Говьсүмбэр аймгийн аялал жуулчлалын өөрчлөлтүүдийн хоорондын хамаарал	138
Хүснэгт 55. Дархан-Уул аймгийн судалгаанд оролцогчдын талаархи мэдээлэл.....	139
Хүснэгт 56. Дархан-Уул аймгийн иргэдээс өгсөн аялал жуулчлалын нөлөөллийн үнэлгээ	139
Хүснэгт 57. Дархан-Уул аймгийн иргэдийн аялал жуулчлалын эерэг ба сөрөг нөлөөллийн тухай ойлголтын зөрүү	142
Хүснэгт 58. Дархан-Уул аймгийн аялал жуулчлалын өөрчлөлтүүдийн хоорондын хамаарал	142
Хүснэгт 59. Дорноговь аймгийн судалгаанд оролцогчдын талаархи мэдээлэл.....	143
Хүснэгт 60. Дорноговь аймгийн иргэдээс өгсөн аялал жуулчлалын нөлөөллийн үнэлгээ	143
Хүснэгт 61. Дорноговь аймгийн иргэдийн аялал жуулчлалын эерэг ба сөрөг нөлөөллийн тухай ойлголтын зөрүү	146
Хүснэгт 62. Дорноговь аймгийн аялал жуулчлалын өөрчлөлтүүдийн хоорондын хамаарал	146
Хүснэгт 63. Дорнод аймгийн судалгаанд оролцогчдын талаархи мэдээлэл.....	147
Хүснэгт 64. Дорнод аймгийн иргэдээс өгсөн аялал жуулчлалын нөлөөллийн үнэлгээ.....	147
Хүснэгт 65. Дорнод аймгийн иргэдийн аялал жуулчлалын эерэг ба сөрөг нөлөөллийн тухай ойлголтын зөрүү	150
Хүснэгт 66. Дорнод аймгийн аялал жуулчлалын өөрчлөлтүүдийн хоорондын хамаарал	150
Хүснэгт 67. Дундговь аймгийн судалгаанд оролцогчдын талаархи мэдээлэл.....	151



Хүснэгт 68. Дундговь аймгийн иргэдээс өгсөн аялал жуулчлалын нөлөөллийн үнэлгээ	151
Хүснэгт 69. Дундговь аймгийн иргэдийн аялал жуулчлалын эерэг ба сөрөг нөлөөллийн тухай ойлголтын зөрүү	154
Хүснэгт 70. Дундговь аймгийн аялал жуулчлалын өөрчлөлтүүдийн хоорондын хамаарал	154
Хүснэгт 71. Завхан аймгийн судалгаанд оролцогчдын талаархи мэдээлэл.....	155
Хүснэгт 72. Завхан аймгийн иргэдээс өгсөн аялал жуулчлалын нөлөөллийн үнэлгээ.....	155
Хүснэгт 73. Завхан аймгийн иргэдийн аялал жуулчлалын эерэг ба сөрөг нөлөөллийн тухай ойлголтын зөрүү	158
Хүснэгт 74. Завхан аймгийн аялал жуулчлалын өөрчлөлтүүдийн хоорондын хамаарал	158
Хүснэгт 75. Орхон аймгийн судалгаанд оролцогчдын талаархи мэдээлэл.....	159
Хүснэгт 76. Орхон аймгийн иргэдээс өгсөн аялал жуулчлалын нөлөөллийн үнэлгээ.....	159
Хүснэгт 77. Орхон аймгийн иргэдийн аялал жуулчлалын эерэг ба сөрөг нөлөөллийн тухай ойлголтын зөрүү	162
Хүснэгт 78. Орхон аймгийн аялал жуулчлалын өөрчлөлтүүдийн хоорондын хамаарал	162
Хүснэгт 79. Өвөрхангай аймгийн судалгаанд оролцогчдын талаархи мэдээлэл.....	163
Хүснэгт 80. Өвөрхангай аймгийн иргэдээс өгсөн аялал жуулчлалын нөлөөллийн үнэлгээ	163
Хүснэгт 81. Өвөрхангай аймгийн иргэдийн аялал жуулчлалын эерэг ба сөрөг нөлөөллийн тухай ойлголтын зөрүү	166
Хүснэгт 82. Өвөрхангай аймгийн аялал жуулчлалын өөрчлөлтүүдийн хоорондын хамаарал	166
Хүснэгт 83. Өмнөговь аймгийн судалгаанд оролцогчдын талаархи мэдээлэл.....	167
Хүснэгт 84. Өмнөговь аймгийн иргэдээс өгсөн аялал жуулчлалын нөлөөллийн үнэлгээ	167
Хүснэгт 85. Өмнөговь аймгийн иргэдийн аялал жуулчлалын эерэг ба сөрөг нөлөөллийн тухай ойлголтын зөрүү	170
Хүснэгт 86. Өмнөговь аймгийн аялал жуулчлалын өөрчлөлтүүдийн хоорондын хамаарал	170

Хүснэгт 87. Сүхбаатар аймгийн судалгаанд оролцогчдын талаархи мэдээлэл.....	171
Хүснэгт 88. Сүхбаатар аймгийн иргэдээс өгсөн аялал жуулчлалын нөлөөллийн үнэлгээ.....	171
Хүснэгт 89. Сүхбаатар аймгийн иргэдийн аялал жуулчлалын эерэг ба сөрөг нөлөөллийн тухай ойлголтын зөрүү.....	174
Хүснэгт 90. Сүхбаатар аймгийн аялал жуулчлалын өөрчлөлтүүдийн хоорондын хамаарал.....	174
Хүснэгт 91. Сэлэнгэ аймгийн судалгаанд оролцогчдын талаархи мэдээлэл.....	175
Хүснэгт 92. Сэлэнгэ аймгийн иргэдээс өгсөн аялал жуулчлалын нөлөөллийн үнэлгээ.....	175
Хүснэгт 93. Сэлэнгэ аймгийн иргэдийн аялал жуулчлалын эерэг ба сөрөг нөлөөллийн тухай ойлголтын зөрүү.....	178
Хүснэгт 94. Сэлэнгэ аймгийн аялал жуулчлалын өөрчлөлтүүдийн хоорондын хамаарал.....	178
Хүснэгт 95. Төв аймгийн судалгаанд оролцогчдын талаархи мэдээлэл.....	179
Хүснэгт 96. Төв аймгийн иргэдээс өгсөн аялал жуулчлалын нөлөөллийн үнэлгээ.....	179
Хүснэгт 97. Төв аймгийн иргэдийн аялал жуулчлалын эерэг ба сөрөг нөлөөллийн тухай ойлголтын зөрүү.....	182
Хүснэгт 98. Төв аймгийн аялал жуулчлалын өөрчлөлтүүдийн хоорондын хамаарал.....	182
Хүснэгт 99. Увс аймгийн судалгаанд оролцогчдын талаархи мэдээлэл.....	183
Хүснэгт 100. Увс аймгийн иргэдээс өгсөн аялал жуулчлалын нөлөөллийн үнэлгээ.....	183
Хүснэгт 101. Увс аймгийн иргэдийн аялал жуулчлалын эерэг ба сөрөг нөлөөллийн тухай ойлголтын зөрүү.....	186
Хүснэгт 102. Увс аймгийн аялал жуулчлалын өөрчлөлтүүдийн хоорондын хамаарал.....	186
Хүснэгт 103. Ховд аймгийн судалгаанд оролцогчдын талаархи мэдээлэл.....	187
Хүснэгт 104. Ховд аймгийн иргэдээс өгсөн аялал жуулчлалын нөлөөллийн үнэлгээ.....	187
Хүснэгт 105. Ховд аймгийн иргэдийн аялал жуулчлалын эерэг ба сөрөг нөлөөллийн тухай ойлголтын зөрүү.....	190

Хүснэгт 106. Ховд аймгийн аялал жуулчлалын өөрчлөлтүүдийн хоорондын хамаарал	190
Хүснэгт 107. Хөвсгөл аймгийн судалгаанд оролцогчдын талаархи мэдээлэл.....	191
Хүснэгт 108. Хөвсгөл аймгийн иргэдээс өгсөн аялал жуулчлалын нөлөөллийн үнэлгээ.....	191
Хүснэгт 109. Хөвсгөл аймгийн иргэдийн аялал жуулчлалын эерэг ба сөрөг нөлөөллийн тухай ойлголтын зөрүү	194
Хүснэгт 110. Хөвсгөл аймгийн аялал жуулчлалын өөрчлөлтүүдийн хоорондын хамаарал	194
Хүснэгт 111. Хэнтий аймгийн судалгаанд оролцогчдын талаархи мэдээлэл.....	195
Хүснэгт 112. Хэнтий аймгийн иргэдээс өгсөн аялал жуулчлалын нөлөөллийн үнэлгээ.....	195
Хүснэгт 113. Хэнтий аймгийн иргэдийн аялал жуулчлалын эерэг ба сөрөг нөлөөллийн тухай ойлголтын зөрүү	198
Хүснэгт 114. Хэнтий аймгийн аялал жуулчлалын өөрчлөлтүүдийн хоорондын хамаарал	198

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Судалгааны хамгийн өндөр болон хамгийн бага үнэлгээ (нийт 4 үзүүлэлтээр).....	18
Зураг 2. Архангай аймгийн иргэдийн мэдлэг, ойлголтын ерөнхий үнэлгээ	35
Зураг 3. Баян-Өлгий аймгийн иргэдийн мэдлэг, ойлголтын ерөнхий үнэлгээ	38
Зураг 4. Баянхонгор аймгийн иргэдийн мэдлэг, ойлголтын ерөнхий үнэлгээ	42
Зураг 5. Булган аймгийн иргэдийн мэдлэг, ойлголтын ерөнхий үнэлгээ	46
Зураг 6. Говь-Алтай аймгийн иргэдийн мэдлэг, ойлголтын ерөнхий үнэлгээ	49
Зураг 7. Говьсүмбэр аймгийн иргэдийн мэдлэг, ойлголтын ерөнхий үнэлгээ	53
Зураг 8. Дархан-Уул аймгийн иргэдийн мэдлэг, ойлголтын ерөнхий үнэлгээ	56
Зураг 9. Дорноговь аймгийн иргэдийн мэдлэг, ойлголтын ерөнхий үнэлгээ	60
Зураг 10. Дорнод аймгийн иргэдийн мэдлэг, ойлголтын ерөнхий үнэлгээ	64
Зураг 11. Дундговь аймгийн иргэдийн мэдлэг, ойлголтын ерөнхий үнэлгээ	67
Зураг 12. Завхан аймгийн иргэдийн мэдлэг, ойлголтын ерөнхий үнэлгээ	71
Зураг 13. Орхон аймгийн иргэдийн мэдлэг, ойлголтын ерөнхий үнэлгээ	74
Зураг 14. Өвөрхангай аймгийн иргэдийн мэдлэг, ойлголтын ерөнхий үнэлгээ	78
Зураг 15. Өмнөговь аймгийн иргэдийн мэдлэг, ойлголтын ерөнхий үнэлгээ	82

Зураг 16. Сүхбаатар аймгийн иргэдийн мэдлэг, ойлголтын ерөнхий үнэлгээ	86
Зураг 17. Сэлэнгэ аймгийн иргэдийн мэдлэг, ойлголтын ерөнхий үнэлгээ	90
Зураг 18. Төв аймгийн иргэдийн мэдлэг, ойлголтын ерөнхий үнэлгээ	94
Зураг 19. Увс аймгийн иргэдийн мэдлэг, ойлголтын ерөнхий үнэлгээ	97
Зураг 20. Ховд аймгийн иргэдийн мэдлэг, ойлголтын ерөнхий үнэлгээ	101
Зураг 21. Хөвсгөл аймгийн иргэдийн мэдлэг, ойлголтын ерөнхий үнэлгээ	105
Зураг 22. Хэнтий аймгийн иргэдийн мэдлэг, ойлголтын ерөнхий үнэлгээ	108

БҮЛЭГ 1. УДИРТГАЛ

1.1 Судалгааны зорилго, зорилт

Зорилго:




Орон нутгийн иргэдийн дэмжлэг, оролцоо өндөр байдаг бүс нутагт Аялал жуулчлалын хөгжил эрчимтэй явагддаг нь сүүлийн хорь гаруй жилийн судалгаагаар нотлогдож¹ нутгийн иргэдийн хандлагыг анхаарч судлах болсон. Тиймээс энэхүү судалгааны зорилго нь аялал жуулчлалын хөгжлийн үйл явцад голлох үүрэг гүйцэтгэгч 21 аймгийн иргэдийн аялал жуулчлалын талаарх мэдлэг, ерөнхий ойлголтыг тодорхойлоход оршино.

Зорилт 1:

Аялал жуулчлалын хөгжлийг дагаж нутгийн иргэдийн амьдрах орчинд гарч буй эдийн засаг, нийгэм соёл, байгаль орчин болоод улс төрийн орчинд бий болж буй эерэг болон сөрөг нөлөөллийг Ап болон Кромптоны тодорхойлсон нөлөөллийн үзүүлэлтүүдийг суурь болгон судлах.



Зорилт 2:



Урт хугацааны тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор нутгийн иргэдийн оролцооны түвшинг тодорхойлох.

Ач холбогдол:

Уг судалгааг хийснээр орон нутаг дах аялал жуулчлалын хөгжлийн төлөвлөгөөг орон нутгийн иргэдийн одоогийн ойлголт, хандлагад суурилан боловсруулах, тэдний оролцоог нэмэгдүүлэх оновчтой арга хэмжээг авч ажиллах боломжийг олгоно.



¹ Özgür, H., Tatoğlu, E., Erdal, U., & Azakli, S. (1985). Resident perceptions of the impact of tourism in a Turkish resort town. *Annals of Tourism Research*, 652-658.

1.2 Судалгааны үндэслэл

Аялал жуулчлал нь гадаад эх үүсвэрээс орлого бүрдүүлэх боломжтой экспортлогч салбар юм. Жуулчдыг хүлээн авагч улс нь гадаад мөнгөн тэмдэгтийн урсгалыг нэмэгдүүлснээр үндэсний төлбөрийн тэнцлийг сайжруулдаг.² Шинэ ажлын байрыг бий болгосноор ажилгүйдлийг бууруулдаг.³ Аялал жуулчлалын хэрэгцээ өсөхтэй зэрэгцээд дэд бүтцийн бүтээн байгуулалт, харилцаа холбоо болон тээврийн салбарын хөрөнгө оруулалтыг идэвхжүүлдэг байна.⁴ Аялал жуулчлал нь орон нутгийн удирдлагын хуримтлуулах татварын хэмжээ хэмжээг нэмэгдүүлэх, эдийн засгийг солонгоруулах эх үүсвэрт тооцогдож байна.⁵ Гэсэн хэдий ч сайн төлөвлөгөө, хяналт хийж чадаагүйгээс үүдэн аялал жуулчлалын эерэг нөлөөллийн үр дүнг сулруулж эсрэгээрээ сөрөг нөлөөллийг бий болгоно. Гадаад иргэдийн эрэлт хэрэгцээнээс үүдэн бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ болоод амьдралын өртөг нэмэгддэг.⁶ Ялангуяа аялал жуулчлалын оргил ачааллын улирлаар байр сууцны эрэлт өссөнөөр байр түрээсийн үнэ, газрын үнэ дагаад өсдөг. Аялал жуулчлалаас орж ирэх нэмэлт орлогын урсгал нь газрын эзэд, бизнес эрхлэгчдэд төвлөрч харин энгийн нутгийн иргэдийн хувьд амьдралын өртөг өсөх нь хүндээр тусах үзэгдэл ажиглагдаж орлогын тэгш бус хуваарилалт үүсэх магадлалтай. Шинэ үүсэх ажлын байрыг дагаад нутгийн иргэд аялал жуулчлалын бүс нутаг руу нүүж нийгэм, соёлын шинэ асуудлууд бий болно. Аялал жуулчлалын хурдацтай хөгжлийн нөлөөгөөр хотжилт, гал түймэр, цагдаа, эмнэлэг зэрэг нийгмийн үйлчилгээ чанарждаг.⁷ Тухайн бүс нутагт нийгмийн арга хэмжээ, амралт зугаалгын үйлчилгээ төрөлждөг.

Аялал жуулчлалын нөлөөгөөр олон соёлыг тээгч жуулчид нь соёлын туршлага солилцох боломжийг бүрдүүлнэ.⁸ Аялал жуулчлал нь урт хугацаанд нийгмийн үнэ цэнэ, итгэл үнэмшил болоод соёлын байдлын өөрчилж байна.⁹ Гадаад жуулчдын нөлөөгөөр нутгийн иргэдийн өмсөх, идэх, амралт, зугаа цэнгэлийн хэв маягт өөрчлөлт гарах магадлалтай байдаг. Энэ нь амьдралын чанарт эерэг нөлөө авчирч болох хэдий ч иргэдийн дотоод соёлын үзүүлэлт буурах сөрөг хандлага ч ажиглагдана. Мөн аялал жуулчлал нь урлаг, урлагийн бүтээл, гар урлал болоод дотоод

² Özgür, H., Tatoğlu, E., Erdal, U., & Azakli, S. (1985). Resident perceptions of the impact of tourism in a Turkish resort town. *Annals of Tourism Research*, 652-658.

³ Sheldon, P.; Var, T. (1984). Resident attitudes to tourism in North Wales. *Tourism Management*, 40-48.

⁴ Inskeep, E. (1991). *Tourism Planning - An Integrated and Sustainable Development*.

⁵ Yasong Wang, Robert E. Pfister, & Duarte B. Morais. (2007). Residents' attitudes toward tourism development: a case study of Washington, NC. Department of Agriculture, Forest Service, Northern Research Station, 411-419.

⁶ An, Y. (2016). Resident's Perception of Tourism Development in Greenville, SC, USA. *All Theses*, 2418.

⁷ Yu WANG, Gang LI, & Xuemei BAI. (2005). A Residential Survey on Urban Tourism Impacts in Harbin. *China Tourism Research*, 116-129.

⁸ Brayley, R., Var, T., & Sheldon, P. (1990). Perceived influence of tourism on social issues. *Annals of Tourism Research*, 285-289.

⁹ Yu WANG, Gang LI, & Xuemei BAI. (2005). A Residential Survey on Urban Tourism Impacts in Harbin. *China Tourism Research*, 116-129.

нутгийн соёл, өв соёлын ялгарлыг ахин сэргээхэд хувь нэмэр болдог.¹⁰ Илүү олон жуулчдыг татахын тулд архитекторын болоод түүхэн дурсгалын хөшөө, цогцолбороо арчилж тордон хамгаалалтанд авдаг байна.¹¹ Соёлын нөлөөллийн хувьд аялал жуулчлал нь үнэ цэнийн систем, хувь хүний зан төлөв, гэр бүлийн харилцаа, холимог амьдралын хэв маяг, нутгийн байгууллагын үйл ажиллагаанд өөрчлөлт оруулдаг байна.¹² Энэ төрлийн нийгмийн нөлөөлөл нь эерэг бас сөрөг байж болно. Аялал жуулчлалыг хөгжүүлэх нь нийгмийн бүлгийн ялгарал үүсч хэт баян хэсэг буюу бизнес эрхлэгч, газрын эзэд байх бол эсрэг талдаа хэт ядуу нийгмийн бүлэг үүсэх эрсдэлтэй.¹³ Учир нь соёлын ялгаатай байдлаас үүдэн өөр соёлыг тээгч иргэд нь тухайн бүс нутагт нийгэм, соёлын зөрчилдөөн үүсгэх хандлагатай байдаг. Аялал жуулчлалын нөлөөлөл нь эмэгтэйчүүдийн хувьд давуу талыг бий болгодог гэсэн судалгаа байдаг.¹⁴ Эмэгтэйчүүд илүү эрх чөлөөтэй болж, ажлын байрны боломжууд нэмэгдэж, боловсролоо дээшлүүлж, гэр бүлийн орлого нэмэгдэн амжиргааны түвшин ахидаг хэдий ч аялал жуулчлал нь гэр бүлийн бүтэц, үнэ цэнэд сөргөөр нөлөөлөхөөс гадна гэр бүл салалтын тоо, биеэ үнэлэлтийг нэмэгдүүлдэг байна. Мөн аялал жуулчлалын нөлөөгөөр ёс суртахууны үнэ цэнэ буурч, согтууруулах ундаа, хар тамхины хэрэглээ өссөнөөр гэмт хэргийн гаралт ихсэхээс гадна нутгийн иргэдийн дунд эмх замбараагүй байдал үүсдэг.¹⁵ Үүнээс гадна иргэд аялал жуулчлалын нөлөөгөөр иргэд хоорондын харилцаа алдагдаж бүхнийг мөнгөн харилцаагаар шийдвэрлэх сонирхолтой болдог. Жуулчлалын оргил ачааллын улирлын үеэр хэт бөөгнөрөл үүсч дуу чимээ ихсэж, бохирдол үүсдэг.¹⁶ Энэ бөөгнөрөлийн нөлөөгөөр жуулчид парк, цэцэрлэгт хүрээлэнгээр тухтай үйлчлүүлж чадахгүй¹⁷ байдал үүсч улмаар аялал жуулчлалын талаар сөрөг ойлголттой болдог байна.

Тогтвортой аялал жуулчлалын хөгжлийн хүрээнд аялал жуулчлалын байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн талаар сүүлийн үеийн судалгаанууд их хийгдэж байна.¹⁸ Сайн төлөвлөөгүй, хяналтгүй бүтээн

¹⁰ Özgür, H., Tatoğlu, E., Erdal, U., & Azakli, S. (1985). Resident perceptions of the impact of tourism in a Turkish resort town. *Annals of Tourism Research*, 652-658.

¹¹ Ling Zhang, Sen Yang, Danni Wang, & Emily Ma. (2020). Perceived value of, and experience with, a World Heritage Site in China—the case of Kaiping Diaolou and villages in China. *Journal of Heritage Tourism*.

¹² Özgür, H., Tatoğlu, E., Erdal, U., & Azakli, S. (1985). Resident perceptions of the impact of tourism in a Turkish resort town. *Annals of Tourism Research*, 652-658.

¹³ de Kadt, E. (1979). *Tourism-Passport to Development?* New York: Oxford University Press.

¹⁴ An, Y. (2016). *Resident's Perception of Tourism Development in Greenville, SC, USA*. All Theses, 2418.

¹⁵ Nuray TÜRKER, & Sevgi ÖZTÜRK. (2013). Perceptions of Residents Towards The Impacts of Tourism in the Küre Mountains National Park, Turkey. *International Journal of Business and Social Science*.

¹⁶ Nuray TÜRKER, & Sevgi ÖZTÜRK. (2013). Perceptions of Residents Towards The Impacts of Tourism in the Küre Mountains National Park, Turkey. *International Journal of Business and Social Science*.

¹⁷ Sirakaya, E., & Choi HwanSuk, C. (2006). Sustainability indicators for managing community tourism. *Tourism Management*, 1274–1289.

¹⁸ B. Tovar, R. Espino, & F. López-del-Pino. (2020). Residents' perceptions and attitudes towards the cruise tourism impact in gran Canaria. *Research in Transportation Business & Management*.

байгууламжууд, гажуудсан хотжилт болон хангалтгүй дэд бүтэц нь байгаль орчин, зэрлэг ан амьтан, ургамал, агаар болон усны бохирдлыг бий болгож байна.¹⁹ Археологийн болон түүхэн ач холбогдолтой эмзэг газар нутгийг даац хэтрүүлэн болон буруу ашигласнаас үүдэн байгаль орчныг доройтуулж байна. Зорих газрын төлөвлөлтийг сайжруулж, дэд бүтцийн бүтээн байгуулалтыг зөв зохион байгуулснаар ус болон агаарын бохирдол, хог хаягдлыг бууруулж орон нутагт эерэг хувь нэмэр оруулах боломжтой байдаг.²⁰ Жуулчид цэвэр, онгон байгалийг илүүд үзэн аялдаг гэдгийг нугтийн иргэд бодолцон байгаль орчин, экологийн асуудлуудаа урьдчилан харж, арчилан торддог байх хэрэгтэй.

1960 аад оны үед аялал жуулчлалын эдийн засгийн эерэг нөлөөллийн талаарх судалгаанууд түлхүү хийгддэг байсан бол 1970 аад оноос эхлэн аялал жуулчлалд шүүмжлэлтэй хандаж эхлэн нийгэм соёлын сөрөг нөлөөллийг сөхөх болсон.²¹ Харин 1980 аас 1990 ээд онуудад тогтвортой аялал жуулчлалын ойлголтын хүрээнд эерэг болон сөрөг нөлөөллийг тэнцвэртэйгээр авч үзэх болсон.²²

Өмнө хийгдэж байсан судалгаануудын дийлэнх нь аялал жуулчлалын эдийн засаг, нийгэм соёл болоод байгаль орчны нөлөөг судалж байсан бол оролцогч талууд аялал жуулчлалын хөгжлийн улс төрийн асуудлуудыг сонирхож эхлэх болсон.²³ Чой болон Сиракаяа нар нь 2006 онд нийгмийн улс төрийн тогтолцоо болон иргэдийн эрхийг харгалзан үзэж аялал жуулчлал дах улс төрийн оролцоог тодорхойлох оролдлогыг хийсэн.²⁴

Аялал жуулчлалын үйл ажиллагаанаас орон нутгийн иргэдэд үзүүлдэг эерэг болон сөрөг нөлөөлөл нь жуулчдын тоо, тэдний яс үндэс, эдийн засгийн үзүүлэлт, байрлах хугацаа болон хамрагдах арга хэмжээнээс ихээхэн хамаардаг. Жуулчдыг хүлээн авагч улсын нийгэм, соёл болон эдийн засгийн бүтэц, нөхцөл байдал нь аялал жуулчлалын нөлөөллийн ойлголтод чухал үзүүлэлт болж байна. Нэг талаараа аялал жуулчлал нь сөрөг нөлөө үзүүлээд байгаа боловч тухайн нутаг оронд эдийн засгийн хувьд өгөөжтэй байх хандлагатай байдаг.²⁵

¹⁹ An, Y. (2016). Resident's Perception of Tourism Development in Greenville, SC, USA. All Theses, 2418.

²⁰ Sirakaya, E., & Choi HwanSuk, C. (2006). Sustainability indicators for managing community tourism. *Tourism Management*, 1274–1289.

²¹ de Kadt, E. (1979). *Tourism-Passport to Development?* NewYork: OxfordUniversity Press.

²² Özgür, H., Tatoğlu, E., Erdal, U., & Azakli, S. (1985). Resident perceptions of the impact of tourism in a Turkish resort town. *Annals of Tourism Research*, 652-658.

²³ Jamal, T & Camargo, B. A. (2018). Tourism governance and policy. *Tourism Management Perspectives*, 205-208.

²⁴ Hong Wu, Seongseop (Sam) Kim, & Antony King Fung Wo. (2020). Residents' perceptions of desired and perceived tourism impact in Hainan Island. *Asia Pacific Journal of Tourism Research*, 583-601.

²⁵ Özgür, H., Tatoğlu, E., Erdal, U., & Azakli, S. (1985). Resident perceptions of the impact of tourism in a Turkish resort town. *Annals of Tourism Research*, 652-658.



1.3 Судалгааны нэр томъёоны тодорхойлолт

Тогтвортой хөгжил (Sustainable development)

Ирээдүй хойч үеийнхээ хэрэгцээ, шаардлагыг хангах чадварыг алдагдуулахгүйгээр өнөөгийн хэрэгцээгээ хангахыг хэлнэ.²⁶

Нутгийн иргэд (local residents)

Эдийн засгийн зонхилох сонирхлын төв нь эдийн засгийн нутаг дэвсгэртээ байрладаг хувь хүмүүсийг хэлнэ.²⁷ (Нутгийн иргэд гэж ижил нутаг оронд зэрэгцэн амьдрахаас илүүтэйгээр нөөцийн талаар ижил сонирхолтой бүлэг хүмүүсийн нэгдлийг хэлнэ.²⁸ Уг судалгаанд нутгийн иргэд гэх ойлголтоор байгаль орчин, зэрлэг ан амьтад тэдний нутаг оронд ойр амьдрах бүлэг хүмүүсийг ойлгох бөгөөд тэднийг аялал жуулчлалын үйл ажиллагаанд хамтатган оролцуулах шаардлагатай байна.

Ойлголт (Perception)

Хувь хүний аливаа нэг бүтээгдэхүүн, үйлчилгээ, газар нутаг болон байгууллагын талаарх тодорхой үзэл бодол, хандлагыг бий болгож буй мэдээллийн субъектив тайлбар юм.²⁹ Иймээс энэхүү судалгаанд ойлголт гэдэг үгийг тухайн нутгийн иргэд аялал жуулчлалын талаар эерэг эсвэл сөрөг ямар бодолтой байгааг тодорхойлж байгааг ойлгоно.

Эдийн засгийн нөлөөлөл (Economic impact)

Эдийн засгийн нөлөөлөл гэдэгт аялал жуулчлалыг хөгжүүлснээр тухайн орон нутагт бий болж буй санхүүгийн үзүүлэлт, үр дүнг ойлгоно.³⁰ Энэ нь ажлын байр нэмэгдэх давуу талтай ч бараа бүтээгдэхүүний үнэ өсөх сул тал гэх мэт эерэг ба сөрөг утгын аль ч утгаар илэрхийлэгдэх болно.

Нийгэм, соёлын нөлөөлөл (Social and cultural impact)

Иргэдийн амьдралын хэв маяг, дотоод соёл, иргэдийн үнэ цэнэ, хандлага, амьдралын чанарт үзүүлж буй аялал жуулчлалын үр нөлөөг ойлгоно.³¹

²⁶ WCED, W. C. (1987). Our common future. Oxford, UK: Oxford University Press.

²⁷ WTO, W. T. (2002). Glossary. Retrieved from WTO: <https://www.unwto.org/glossary-tourism-terms>

²⁸ Nagarjuna, G. (2015). Local Community Involvement in Tourism: A Content Analysis of Websites of Wildlife Resorts. Atna, J Tour Stud, 13-21.

²⁹ Barnes, J. (2015). Perception in tourism & hospitality: A meta anylasis. Assumption Journal, 89-107.

³⁰ Szell, A. B. (2012). Attitudes and Perceptions of Local Residents and Tourists Toward the Protected Area of Retezat National Park, Romania. Master thesis, 59.

³¹ Hong Wu, Seongseop (Sam) Kim, & Antony King Fung Wo. (2020). Residents' perceptions of desired and perceived tourism impact in Hainan Island. Asia Pacific Journal of Tourism Research, 583-601.

Байгаль орчны нөлөөлөл (Environmental impact)

Аялал жуулчлалыг дагаад хүний бөөгнөрөл үүсч орчны дуу чимээ ихсэх, ан амьтан үргэх зэрэг сул талтай³² боловч жуулчидыг татахын тулд нутгийн байгаль хамгаалал, тусгай хамгаалалттай газар нутгийн менежмент сайжирдаг давуу талууд бий болдог.³³ Энэхүү судалгаанд Аялал жуулчлалыг хөгжүүлэхэд хүний оролцоотой хүрээлэн буй орчин, зэрлэг ан амьтан, ургамалд учирч болох эерэг болон сөрөг нөлөөллийг хамтатган ойлгоно.

Улс төрийн нөлөөлөл (Political impact)

Аялал жуулчлалын нөлөөллийн судалгаанд сүүлийн үед шинээр нэмэгдэж ирсэн ойлголт болох улс төрийн оролцоо нь чухал ач холбогдолтой.³⁴ Нутгийн иргэд шийдвэр гаргах түвшинд оролцоотой байж улс төр, төрийн захирагааны үйл ажиллагаанд хэрхэн хамаарагдаж, ямар ойлголттой байгааг илэрхийлэх ойлголт.

³² Sirakaya, E., & Choi HwanSuk, C. (2006). Sustainability indicators for managing community tourism. *Tourism Management*, 1274–1289.

³³ Dogan GURSOYA, E. B. (2019). Residents' perceptions of hotels' corporate social responsibility initiatives T and its impact on residents' sentiments to community and support for additional tourism development. *Journal of Hospitality and Tourism Management*, 117–128.

³⁴ Sirakaya, E., & Choi HwanSuk, C. (2006). Sustainability indicators for managing community tourism. *Tourism Management*, 1274–1289.

БҮЛЭГ 2. СУДАЛГААНЫ АРГАЗҮЙ

2.1 Түүвэрлэлт

Судалгааны зорилгод нийцсэн түүврийн хүрээ нь 21 аймгийн нийт өрх ба түүврийн эх олонлогоор 21 аймгийн 2020 оны жилийн эцсийн хүн амын тоо, үүнээс 15-с дээш насны бүлгийг сонгон авсан. Мөн түүвэрлэлтийн үндсэн таамаглал нь эх олонлогийг хэвийн тархалттай гэж үзээд энгийн санамсаргүй түүврийн аргачлалаар түүврийн хэмжээг сонгох томъёог ашигласан болно. Түүврийн хамгийн бага оновчтой хэмжээг 95%-ийн итгэх магадлалтай, +/- 5%-ийн алдааны хязгаартай байхаар сонгон эх олонлогийн хэмжээг 2020 оны жилийн эцсийн хүн ам, өрхийн тоогоор тооцоолоход дунджаар 382 болно. Иймээс 21 аймаг бүрээс дунджаар 382 буюу нийт түүврийн оновчтой хэмжээ 8022 гэж тооцоолсон. Дэлгэрэнгүйг Хүснэгт 1-д үзүүлэв.

Хүснэгт 1. Түүврийн хэмжээ (бүх аймгаар)

№	Аймаг	Хүн ам (2020)	Хүн ам (15-с дээш насныхан 2020)	Түүврийн хэмжээ
1	Архангай	94,088	86673	383
2	Баян-Өлгий	110,597	68228	383
3	Баянхонгор	88,955	60081	382
4	Булган	61,955	43185	381
5	Говь-Алтай	57,674	40321	381
6	Говьсүмбэр	17,965	11746	373
7	Дархан-Уул	106,909	70665	383
8	Дорноговь	71,207	48277	382
9	Дорнод	83,087	55944	382
10	Дундговь	46,981	32758	380
11	Завхан	72,763	50473	382
12	Орхон	107,765	72403	383
13	Өвөрхангай	115,732	79751	383

14	Өмнөговь	70,371	47751	382
15	Сүхбаатар	63,822	43643	381
16	Сэлэнгэ	109,285	75069	383
17	Төв	93,162	64091	382
18	Увс	83,524	55523	382
19	Ховд	90,533	58589	382
20	Хөвсгөл	135,705	92743	383
21	Хэнтий	78,172	53624	382
		3,357,542	1211538	382

Эх сурвалж: Монгол улсад оршин суугаа хүн амын тоо, насны бүлэг, баг/хороогоор
https://www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NS0_0300_067V2

2.2 Өгөгдөл цуглуулалт

Судалгааны объектоор Монгол улсын 21 аймгийн иргэдийг сонгосон ба 2021 оны 7-р сарын 1-ээс 9-р сарын 20 хүртэл 80 хоногийн хугацаанд санамсаргүй түүврийн аргаар 2100 ширхэг асуулга хэвлэмэл хэлбэрээр тараагдсан ба аймгуудын байгаль орчин, аялал жуулчлалын мэргэжилтэнгүүдтэй хамтарч ажилласан ба 1778 асуулга судалгааг хүчинтэй гэж тооцсон болно.

Урьдчилсан судалгааг 3 аймгаас авсан бөгөөд 1034 асуулгыг хүчинтэй гэж үзэж нэмж тооцоолсон. Мөн онлайн хэлбэрээр асуулгын линкээ илгээснээс 1604 асуулга бөглөгдөн ирсэн, иймд нийт 4415 судалгааг шаардлага хангасан хэмээн үзэж боловсруулалт хийсэн. Уг тоон үзүүлэлт нь оновчтой түүврийн хэмжээний 55% байгаа нь орон нутагт онлайнаар асуулга бөглүүлэх нь техник, харилцаа холбооны саатал их байгаатай холбоотой, нөгөө талаас цар тахалтай холбоотой иргэд цаасан судалгааг бөглөх нь аюултай гэж үзэн татгалзсан асуудал гарч байснаас үүдсэн гэж дүгнэсэн. Хэдий асуудал байсан ч нийт 4415 гэсэн тоон үзүүлэлт нь эх олонлогоо төлөөлөх хангалттай чадвартай гэж үзэж байна. Дэлгэрэнгүйг Хүснэгт 2-д үзүүлэв.



Хүснэгт 2. Аймгуудаас ирүүлсэн шаардлага хангасан асуулгын тоон үзүүлэлт (бүх аймгаар)

№	Аймаг	Хэвлэмэл асуулгын тоо		Онлайн асуулгын тоо	Ний тоо
		Урьдчилсан судалгаа	Үндсэн судалгаа		
1	Архангай	461	70	69	600
2	Баян-Өлгий		104	21	125
3	Баянхонгор		96	163	259
4	Булган		100	67	167
5	Говь-Алтай		31	29	60
6	Говьсүмбэр		134	17	151
7	Дархан-Уул		95	71	166
8	Дорноговь		211	144	355
9	Дорнод		94	58	152
10	Дундговь		104	135	239
11	Завхан		101	75	176
12	Орхон	393	-	135	528
13	Өвөрхангай		-	41	41
14	Өмнөговь		103	157	260
15	Сүхбаатар		133	75	208
16	Сэлэнгэ		104	11	115
17	Төв		-	28	28
18	Увс		129	107	236
19	Ховд	180	91	67	338
20	Хөвсгөл		33	35	68
21	Хэнтий		45	98	143
	Нийт	1034	1778	1603	4415

Эх сурвалж: Судалгааны үр дүн

2.3 Судалгааны аргачлал

Судалгааны асуулга 5 хэсэг нийт 46 асуулгатай бөгөөд нэгдүгээр хэсэгт судалгаанд оролцогчдын ерөнхий нөхцөлийн талаархи 6 асуулга, хоёрдугаар хэсэгт “Эдийн засгийн өөрчлөлтүүд”-ийн талаархи 10 асуулга, гуравдугаар хэсэгт “Нийгэм, соёлын өөрчлөлтүүд”-ийн 10 асуулга, дөрөвдүгээр хэсэгт “Байгаль орчны өөрчлөлтүүд”-ийн талаархи 10 асуулга, тавдугаар хэсэгт “Төр, захиргааны үйл ажиллагааны өөрчлөлтүүд”-ийг агуулсан 10 асуулгаас бүрдсэн.

Аялал жуулчлалын нөлөөлөл бүхий өөрчлөлтүүдийн хувьсагчдыг үнэлэхдээ Лайкертын 5 шатлалт онооны хэмжилтээр шалгасан болно. Үүнд: Судалгаанд оролцогч иргэн тухайн нөлөөллийн талаархи өөрийн мэдлэг ойлголтоо үнэлэхдээ “Мэдэхгүй” бол 1 оноо, “Бага зэрэг” мэдэх бол 2 оноо, “Дунд зэрэг” мэдэх бол 3 оноо, “Их” мэдлэгтэй бол 4 оноо, “Маш их” мэдлэгтэй бол 5 оноо тус тус өгөх юм.

Судалгааны үр дүнг IBM SPSS 26 програм ашиглан боловсруулалт хийн, судалгааны зорилт болох «Аялал жуулчлалын талаарх орон нутгийн иргэдийн ойлголтын түвшинг аймаг бүрээр тодорхойлох»-н тулд тойм статистикийн шинжилгээ, мөн «Аялал жуулчлалын талаарх ойлголтуудын харилцан хамаарлыг тодорхойлох»-н зорилтыг хангахын тулд хүчин зүйлсийн найдвартай байдлын шинжилгээ, корреляцийн шинжилгээ, хоёр үл хамаарсан түүврийн t шалгуурын шинжилгээнүүдийг хийсэн болно.

Хүчин зүйлсийн найдвартай байдлын шинжилгээнд асуулгуудын ачааллыг 0.5-с их байхаар тооцсон. Корреляцийн шинжилгээнд хамаарлын коэффициентийн авах утга-1-д ойртох тусам хүчтэй сөрөг, 1-д ойртох тусам хүчтэй эерэг, 0-д ойрхон байх тусам сул хамааралтай гэж тооцсон болно. Мөн статистик ач холбогдлын түвшинг шинжилгээ бүрт тохирох утгаар авч, одны дүрслэлийг ашигласан болно.



БҮЛЭГ 3. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

3.1 Судалгаанд оролцогчдын талаархи мэдээлэл

Судалгаанд оролцогчдын талаархи ерөнхий мэдээлэл

Судалгаанд оролцогсдын 57.1% нь эмэгтэй, 25~44 насныхан 58.4% байна. Онлайн болон цаасан гэсэн холимог хэлбэрээр авсан тул 21 аймгаас оролцоотой гарсан ба 17.8% нь нутагтаа 16-20 жил оршин сууж байгаа, 46.0% нь 20 жилээс дээш амьдарч байгаа нутгийн уугуул иргэд байна.

Судалгаанд оролцогсдын 45.1% нь төрийн албан хаагч бөгөөд 21.9% нь бусад (малчин, тариаланчин зэрэг) ангилалд багтаж байна. Эрхэлж буй ажил, хөдөлмөр, бизнесийн үйл ажиллагаа аялал жуулчлалтай хамааралтай эсэхэд 41.6% нь огт хамааралгүй, 37.4% нь дам хамааралтай, 21.0% нь шууд хамааралтай байна. Дэлгэрэнгүйг Хүснэгт 3-д үзүүлэв, аймаг тус бүрийн дэлгэрэнгүйг Хавсралт-д тус тус үзүүлэв.

Хүснэгт 3. Судалгаанд хамрагдсан хүмүүсийн ерөнхий мэдээлэл (бүх аймгаар)

Хүйс	Тоо	Хувь	Оршин суугаа аймаг	Тоо	Хувь
Эрэгтэй	1892	42.9	Архангай	600	13.6
Эмэгтэй	2523	57.1	Баян-Өлгий	125	2.8
Нас	Тоо	Хувь	Баянхонгор	260	5.9
15~24	926	21.0	Булган	167	3.8
25~34	1600	36.2	Говь-Алтай	60	1.4
35~44	979	22.2	Говьсүмбэр	151	3.4
45~54	623	14.1	Дархан-Уул	166	3.8
55~64	232	5.3	Дорноговь	355	8.0
65-с дээш	55	1.2	Дорнод	152	3.4
Эрхэлж буй ажил, хөдөлмөр, үйл ажиллагаа	Тоо	Хувь	Дундговь	239	5.4
Оюутан, сурагч	609	13.8	Завхан	176	4.0

Үйлчилгээ эрхлэгч	443	10.0	Орхон	528	12.0
Үйлдвэрлэл эрхлэгч	403	9.1	Өвөрхангай	41	.9
Төрийн албан хаагч	1993	45.1	Өмнөговь	260	5.9
Бусад	967	21.9	Сүхбаатар	208	4.7
Эрхэлж буй ажил, хөдөлмөр, бизнесийн үйл ажиллагаа аялал жуулчлалтай хамааралтай эсэх	Тоо	Хувь	Сэлэнгэ	115	2.6
			Төв	28	.6
			Увс	236	5.3
Огт хамааралгүй	1835	41.6	Ховд	338	7.7
Дам хамааралтай	1653	37.4	Хөвсгөл	67	1.5
Шууд хамааралтай	927	21.0	Хэнтий	143	3.2
Тухайн аймагтаа оршин сууж байгаа жил	Тоо	Хувь		Тоо	Хувь
1-5 жил	410	9.3			
6-10 жил	545	12.3	16-20 жил	784	17.8
11-15 жил	643	14.6	20 жилээс дээш	2033	46.0
Нийт	4415	100	Нийт	4415	100

Эх сурвалж: Судалгааны үр дүн

Мөн солбицсон хүснэгтээр ажил эрхлэлтийн байдал болон эрхэлж буй ажил, хөдөлмөр, бизнесийн үйл ажиллагаа аялал жуулчлалтай хамааралтай эсэхэд дүн шинжилгээ хийсэн болно.

Уг судалгаанд оролцсон үйлдвэрлэл эрхлэгч иргэдийн бизнесийн үйл ажиллагаа аялал жуулчлалтай шууд (42.2%) болон дам (30.3%) хамааралтай, үйлчилгээ эрхлэгч иргэдийн бизнесийн үйл ажиллагаа аялал жуулчлалтай дам (42.2%) хамааралтай гэсэн хариултыг өгсөн байна. Мөн уг судалгаанд оролцсон төрийн албан хаагчдын ажил үйлчилгээ нь аялал жуулчлалтай дам (40.3%) хамааралтай гарсан байна. Дэлгэрэнгүйг Хүснэгт 4-д үзүүлээ.



Хүснэгт 4. Хөдөлмөр эрхлэлт ба аялал жуулчлалын үйл ажиллагааны хамаарал (бүх аймгаар)

			Огт хамааралгүй	Дам хамааралтай	Шууд хамааралтай	Нийт
1	Оюутан, сурагч	Тоо	353	174	82	609
		Хувь	58.0%	28.6%	13.5%	100.0%
2	Үйлчилгээ эрхлэгч	Тоо	138	187	118	443
		Хувь	31.2%	42.2%	26.6%	100.0%
3	Үйлдвэрлэл эрхлэгч	Тоо	91	190	122	403
		Хувь	22.6%	47.1%	30.3%	100.0%
4	Төрийн албан хаагч	Тоо	699	804	490	1993
		Хувь	35.1%	40.3%	24.6%	100.0%
5	Бусад	Тоо	554	298	115	967
		Хувь	57.3%	30.8%	11.9%	100.0%
НИЙТ		Тоо	1835	1653	927	4415
		Хувь	41.6%	37.4%	21.0%	100.0%

Эх сурвалж: Судалгааны үр дүн

3.2 Аялал жуулчлалын нөлөөллийн үнэлгээ

Тойм статистикийн шинжилгээг асуулга нэг бүрийг үнэлсэн дундаж үнэлгээгээр тодорхойлсон бөгөөд үр дүнг нэгтгэн Хүснэгт 5-д үзүүлсэн болно.

Судалгааны үр дүнд иргэдийн аялал жуулчлалын нөлөөлөл бүхий өөрчлөлтүүдийн талаархи ерөнхий ойлголт бага, дунд зэрэг гэсэн үзүүлэлттэй гарсан. (5 хүртэлх онооны шатлалаас $m=2.52-3.66$)

Өндөр үнэлгээтэй буюу “их болон маш их” мэдлэгтэй гэсэн үнэлгээтэй асуулга гараагүй ба уг судалгаанд хамгийн өндөр үзүүлэлттэй нь Нийгэм, соёлын болон Эдийн засгийн ЭЕРЭГ өөрчлөлтүүд байна. Үүнд: “Орон нутгийн байгалийн үзэмжит газрын нэр хүндийг өсгөдөг”, “Түүх, соёлын өвийн мэдлэг, ашиглалтыг сайжруулдаг”, “Аялал жуулчлалыг дагаж шинэ мэдлэг, соёлын шинэ хэрэглээ үүсдэг” зэрэг нийгэм, соёлын өөрчлөлтүүд, “Орон нутгийн худалдаа, үйлчилгээг идэвхжүүлдэг”, “Худалдаа, үйлчилгээний ажлын байрыг нэмэгдүүлдэг” зэрэг эдийн засгийн өөрчлөлтүүдийн асуултанд нутгийн иргэд “ДУНД” зэрэг мэднэ ($m=3.42$ -с дээш) гэж хариулжээ.

Хамгийн бага үнэлгээ буюу “мэдэхгүй” гэсэн үнэлгээ дундаж үзүүлэлтээр гараагүй бөгөөд уг судалгаанд хамгийн бага үзүүлэлттэй нь Төр, захиргаа болон Эдийн засгийн СӨРӨГ өөрчлөлтүүдээс гарчээ. Тухайлбал, “Аялал жуулчлалын улирлаар үйлчилгээний газруудад татвар, торгуулийн дарамт нэмэгддэг”, “Аялал жуулчлалыг хөгжүүлснээр ХАА-н (газар тариалан, мал аж ахуй) ажиллах хүчний хомсдол үүсдэг” зэрэг эдийн засгийн өөрчлөлтүүд, “Аялал жуулчлалыг дагаж төр, захиргааны хүнд суртал нэмэгддэг”, “Төр, захиргааны бүтэц, хүний нөөцийн өөрчлөлт нь аялал жуулчлалын бодлого, стратегийн хэрэгжилтэд саад учруулдаг”, “Аялал жуулчлалыг дагаж авилга, хээл хахуулийн гэмт хэрэг нэмэгддэг” үэрэг төр, засгийн өөрчлөлтүүдийн асуултанд нутгийн иргэд “БАГА” зэрэг мэднэ (m=2.70-с доош) гэж хариулжээ.

Хүснэгт 5. Аялал жуулчлалын нөлөөллийн үнэлгээний түвшин (бүх аймгаар)



Асуулгын утга	Дундаж утга	Стандарт хазайлт	Аялал жуулчлалын нөлөөлөл	
			хувьсагч	нөлөөлөл
Аялал жуулчлал нь орон нутгийн байгалийн үзэмжит газрын нэр хүндийг өсгөдөг	3.66	1.123	нийгэм, соёл	ээрэг
Аялал жуулчлал нь түүх, соёлын өвийн мэдлэг, ашиглалтыг сайжруулдаг	3.66	1.051	нийгэм, соёл	ээрэг
Аялал жуулчлал нь орон нутгийн худалдаа, үйлчилгээг идэвхжүүлдэг	3.53	1.137	эдийн засаг	ээрэг
Аялал жуулчлалыг дагаж шинэ мэдлэг, соёлын шинэ хэрэглээ үүсдэг	3.43	1.122	нийгэм, соёл	ээрэг



Аялал жуулчлал нь худалдаа, үйлчилгээний ажлын байрыг нэмэгдүүлдэг	3.42	1.150	эдийн засаг	ээрэг
Аялал жуулчлалыг дагаж бизнесийн шинэ төрлүүд нэмэгддэг	3.42	1.156	эдийн засаг	ээрэг
Аялал жуулчлал нь шашин, урлаг, соёлын арга хэмжээг нэмэгдүүлдэг	3.42	1.119	нийгэм, соёл	ээрэг
Аялал жуулчлалыг дагаж ундны ус, эрчим хүч, зорчигч тээвэр, зам харилцааны дэд бүтэц сайжирдаг	3.40	1.204	нийгэм, соёл	ээрэг
Аялал жуулчлал нь хог хаягдлыг нэмэгдүүлдэг	3.40	1.205	байгаль	сөрөг
Аялал жуулчлалыг дагаж хяналтгүй олон салаа замууд бий болж хөрсийг доройтуулдаг	3.37	1.212	байгаль	сөрөг
Аялал жуулчлалыг дагаж хуванцар болон нийлэг материалын хэрэглээ өсдөг	3.37	1.256	байгаль	сөрөг
Аялал жуулчлал нь орон нутгийн татвар, хураамжийн орлогыг нэмэгдүүлдэг	3.30	1.215	эдийн засаг	ээрэг
Аялал жуулчлал нь жуулчид, орон нутгийн иргэдэд хог хаягдлын тухай мэдлэгийг нэмэгдүүлдэг	3.26	1.139	байгаль	ээрэг
Аялал жуулчлалын бизнес хувь хүн, өрхийн орлогыг нэмэгдүүлдэг	3.23	1.250	эдийн засаг	ээрэг
Аялал жуулчлал нь ан амьтан, ургамлын амьдрах орчныг өөрчилдөг	3.18	1.206	байгаль	сөрөг
Аялал жуулчлал нь жуулчид, орон нутгийн иргэдийн эко мэдлэгийг нэмэгдүүлдэг	3.17	1.145	байгаль	ээрэг
Аялал жуулчлалыг дагаж иргэдийн нийгмийн идэвх, оролцоо нэмэгддэг	3.14	1.111	төр, захиргаа	ээрэг
Аялал жуулчлал нь өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ, тарифыг хөөрөгддөг	3.10	1.167	эдийн засаг	сөрөг

Аялал жуулчлалыг дагаж салбар дундын уялдаа холбоо сайжирдаг	3.09	1.152	төр, захиргаа	ээрэг
Аялал жуулчлалыг дагаж байгаль хамгааллын үйл ажиллагаа сайжирдаг	3.08	1.175	байгаль	ээрэг
Аялал жуулчлалыг дагаж төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаа сайжирдаг	3.06	1.153	төр, захиргаа	ээрэг
Аялал жуулчлалыг дагаж хөгжлийн бодлого боловсруулах, төлөвлөх үйл ажиллагаа сайжирдаг	3.04	1.165	төр, захиргаа	ээрэг
Аялал жуулчлалыг дагаж байгаль хамгаалах нөхөрлөл, бүлгийн үйл ажиллагаа сайжирдаг	3.03	1.184	байгаль	ээрэг
Аялал жуулчлал нь байгалийн унаган төрхийг доройтуулдаг	3.02	1.226	байгаль	сөрөг
Аялал жуулчлалыг дагаж газар, үл хөдлөх хөрөнгийн үнэ өсдөг	3.00	1.253	эдийн засаг	сөрөг
Аялал жуулчлалыг дагаж зэрлэг ан амьтан болон ургамал хамгаалал, бүртгэлжүүлэлт сайжирдаг	2.95	1.211	байгаль	ээрэг
Аялал жуулчлал нь орон нутгийн аюулгүй байдлыг хангах үйлчилгээний ачааллыг нэмэгдүүлдэг (эмнэлэг, цагдаа зэрэг)	2.91	1.176	нийгэм, соёл	сөрөг
Аялал жуулчлал нь орон нутгийн төрийн бус байгууллагуудыг дэмждэг	2.89	1.225	төр, захиргаа	ээрэг
Аялал жуулчлалын улирал дуусахад ажилгүй иргэдийн тоо нэмэгддэг	2.88	1.196	эдийн засаг	сөрөг
Алсын хараагүй бодлого, төлөвлөлт нь аялал жуулчлалын үйл ажиллагааг доголдуулдаг	2.88	1.260	төр, захиргаа	сөрөг
Аялал жуулчлалыг дагаж зам тээврийн осол, хэрэг, зөрчлийн тоо нэмэгддэг	2.87	1.160	нийгэм, соёл	сөрөг




Аялал жуулчлал нь иргэдийн ахуй, соёлын унаган төрхийг алдагдуулдаг	2.86	1.229	нийгэм, соёл	сөрөг
Аялал жуулчлалын эмх замбраагүй байдал нь төр, захиргааны ажлын ачааллыг нэмэгдүүлдэг	2.75	1.273	төр, захиргаа	сөрөг
Аялал жуулчлалыг дагаж бизнесийн ёс зүйгүй үйлдлүүд нэмэгддэг	2.71	1.224	нийгэм, соёл	сөрөг
Аялал жуулчлал нь иргэдийн амар тайван байдлыг алдагдуулдаг	2.70	1.151	нийгэм, соёл	сөрөг
Аялал жуулчлалын улирлаар үйлчилгээний газруудад татвар, торгуулийн дарамт нэмэгддэг	2.66	1.265	эдийн засаг	сөрөг
Аялал жуулчлалыг дагаж төр, захиргааны хүнд суртал нэмэгддэг	2.62	1.254	төр, захиргаа	сөрөг
Төр, захиргааны бүтэц, хүний нөөцийн өөрчлөлт нь аялал жуулчлалын бодлого, стратегийн хэрэгжилтэд саад учруулдаг	2.60	1.252	төр, захиргаа	сөрөг
Аялал жуулчлалыг дагаж авилга, хээл хахуулийн гэмт хэрэг нэмэгддэг	2.58	1.300	төр, захиргаа	сөрөг
Аялал жуулчлалыг хөгжүүлснээр ХАА-н (газар тариалан, мал аж ахуй) ажиллах хүчний хомсдол үүсдэг	2.52	1.231	эдийн засаг	сөрөг

Эх сурвалж: Судалгааны үр дүн

Аймаг тус бүрийн үзүүлэлтийг Хавсралт-д дэлгэрэнгүй харуулсан бөгөөд онцлох зарим үзүүлэлтээс дурдвал, өндөр үнэлгээтэй буюу “их” ($m=4.00-4.99$) мэдлэгтэй гэсэн үнэлгээтэй асуулга нь эерэг утгад 5 аймаг, сөрөг утгад 1 аймгийн үзүүлэлтэд гарсан бол хамгийн бага үнэлгээ буюу “мэдэхгүй” ($m=1.00-1.99$) гэсэн үнэлгээтэй асуулга сөрөг утгад 3 аймгийн үзүүлэлтэд гарсан байна.

Нийт 4 үзүүлэлтийг 3-с дээш үнэлгээтэй буюу мэдлэг ойлголт сайтай иргэд бүхий аймгууд Архангай, Орхон, Ховд аймаг бол 3-с доош үнэлгээг өгсөн Баянхонгор, Дархан-Уул, Дорнод, Увс аймгийн иргэд байна (Зураг 1).

Зураг 1. Судалгааны хамгийн өндөр болон хамгийн бага үнэлгээ (нийт 4 үзүүлэлтээр)



Булган аймгийн оролцогсад байгаль орчны өөрчлөлтүүдээс “Аялал жуулчлалыг дагаж хуванцар болон нийлэг материалын хэрэглээ өсдөг” ($m=4.13$) гэсэн сөрөг нөлөөллийн мэдлэг хамгийн ихтэй байна. Мөн эдийн засгийн эерэг нөлөөлөл болох “Аялал жуулчлал нь орон нутгийн худалдаа, үйлчилгээг идэвхжүүлдэг” тухайд Говь-Алтай ($m=4.13$) ба Хөвсгөл аймаг ($m=4.02$) өндөр үнэлгээг өгсөн. Нийгэм, соёлын эерэг нөлөөлөл өөрчлөлтүүд болох “Аялал жуулчлал нь орон нутгийн байгалийн үзэмжит газрын нэр хүндийг өсгөдөг” талаар Төв аймаг ($m=4.29$), Өвөрхангай аймаг ($m=4.02$) гэсэн үнэлгээг, “Аялал жуулчлалыг дагаж ундны ус, эрчим хүч, зорчигч тээвэр, зам харилцааны дэд бүтэц сайжирдаг” талаар Ховд аймаг ($m=4.16$) үнэлгээг, “Аялал жуулчлал нь түүх, соёлын өвийн мэдлэг, ашиглалтыг сайжруулдаг” хэмээх утгад Өвөрхангай аймаг ($m=4.05$), Төв аймаг ($m=4.04$), Хөвсгөл аймаг ($m=4.00$) тус тус өндөр мэдлэгтэй гэсэн үнэлгээг өгсөн байна.

Харин хамгийн бага үнэлгээг эдийн засгийн өөрчлөлтүүдээс сөрөг нөлөөлөл болох “Аялал жуулчлалыг хөгжүүлснээр ХАА-н (газар тариалан, мал аж ахуй) ажиллах хүчний хомсдол үүсдэг” талаарх мэдлэг ойлголт Дундговь ($m=1.85$) болон Төв аймгийн ($m=1.86$) иргэд багатай байна гэсэн үзүүлэлт гарчээ.



3.3 Судалгааны найдвартай ба үндэслэлтэй байдал

Хүснэгт 6-д иргэдийн аялал жуулчлалын талаарх мэдлэг, ойлголтын талаархи хүчин зүйлийн шинжилгээний үр дүн болон найдвартай байдлын шинжилгээний үр дүнг үзүүлээ. КМО шалгуурын үр дүн 0.961, бодит гүйцэтгэл 57.212% гарсан нь түүврийн тоо хангалттай хүрэлцээтэй, Бартлеттийн тестийн ач холбогдол илэрхийлэх утга ($\text{sig}=.000$) статистик ач холбогдолтой гарсан тул хүчин зүйлийн шинжилгээ үр дүнтэй гарсан болно. Хувьсагчдын өндөр ачаалалтай утгыг 0.5-с их байхаар тогтоож, 0.5-с бага утга үзүүлсэн асуулга гарвал хасч тооцоолох болно. Уг судалгаанд хасагдсан утга байхгүй, хувьсагчийг тайлбарлах хүч статистик ач холбогдолтой асуултууд байсан. Мөн онолд тулгуурлан асуулгуудаа 4 хувьсагч болгон хуваасан ба бусад судлаачдын адилаар “Эдийн засгийн өөрчлөлтүүд”, “Нийгэм, соёлын өөрчлөлтүүд”, “Байгаль орчны өөрчлөлтүүд”, “Төр, захиргааны үйл ажиллагааны өөрчлөлтүүд” гэж тус тус нэрлэсэн. Асуултуудын найдвартай байдлыг илэрхийлэх Кронбах альфа коэффициент 1-д их ойрхон, буюу 0.8-с их гарсан (0.845-0.889) судалгааны асуулга оновчтой гэж дүгнэн, дараах 4 бүлэг 40 асуулгуудаар боловсруулалт хийх нь ҮНДЭСЛЭЛТЭЙ бөгөөд НАЙДВАРТАЙ гэж үзээд дараагийн шинжилгээнүүд болох ялгаатай утга илрүүлэх болох харилцан хамаарлын шинжилгээнүүдийг хийсэн болно.

Хүснэгт 6. Хүчин зүйлийн шинжилгээний үр дүн болон найдвартай байдлын шинжилгээ (бүх аймгаар)

Хувьсагч	Асуулгын утга	Factor loading	Eigen value	% of variance	Cronbach's Alpha
Эдийн засгийн өөрчлөлтүүд	Аялал жуулчлал нь орон нутгийн татвар, хураамжийн орлогыг нэмэгдүүлдэг	.725	13.749	34.373	.868
	Аялал жуулчлал нь худалдаа, үйлчилгээний ажлын байрыг нэмэгдүүлдэг	.725			
	Аялал жуулчлалыг дагаж бизнесийн шинэ төрлүүд нэмэгддэг	.712			
	Аялал жуулчлалыг дагаж газар, үл хөдлөх хөрөнгийн үнэ өсдөг	.702			
	Аялал жуулчлал нь өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ, тарифыг хөөрөгддөг	.675			
	Аялал жуулчлал нь орон нутгийн худалдаа, үйлчилгээг идэвхжүүлдэг	.672			
	Аялал жуулчлалын бизнес хувь хүн, өрхийн орлогыг нэмэгдүүлдэг	.656			
	Аялал жуулчлалын улирлаар үйлчилгээний газруудад татвар, торгуулийн дарамт нэмэгддэг	.644			
	Аялал жуулчлалын улирал дуусахад ажилгүй иргэдийн тоо нэмэгддэг	.635			
	Аялал жуулчлалыг хөгжүүлснээр ХАА-н (газар тариалан, мал аж ахуй) ажиллах хүчний хомсдол үүсдэг	.620			



Нийгэм, соёлын өөрчлөлтүүд	Аялал жуулчлал нь орон нутгийн аюулгүй байдлыг хангах үйлчилгээний ачааллыг нэмэгдүүлдэг (эмнэлэг, цагдаа зэрэг)	.691	4.945	12.362	.856
	Аялал жуулчлал нь шашин, урлаг, соёлын арга хэмжээг нэмэгдүүлдэг	.686			
	Аялал жуулчлалыг дагаж шинэ мэдлэг, соёлын шинэ хэрэглээ үүсдэг	.674			
	Аялал жуулчлалыг дагаж зам тээврийн осол, хэрэг, зөрчлийн тоо нэмэгддэг	.672			
	Аялал жуулчлал нь иргэдийн ахуй, соёлын унаган төрхийг алдагдуулдаг	.659			
	Аялал жуулчлалыг дагаж бизнесийн ёс зүйгүй үйлдлүүд нэмэгддэг	.659			
	Аялал жуулчлал нь иргэдийн амар тайван байдлыг алдагдуулдаг	.657			
	Аялал жуулчлал нь түүх, соёлын өвийн мэдлэг, ашиглалтыг сайжруулдаг	.657			
	Аялал жуулчлал нь орон нутгийн байгалийн үзэмжит газрын нэр хүндийг өсгөдөг	.642			
	Аялал жуулчлалыг дагаж ундны ус, эрчим хүч, зорчигч тээвэр, зам харилцааны дэд бүтэц сайжирдаг	.604			

Байгаль орчны өөрчлөлтүүд	Аялал жуулчлал нь ан амьтан, ургамлын амьдрах орчныг өөрчилдөг	.688	2.462	6.155	.845
	Аялал жуулчлал нь жуулчид, орон нутгийн иргэдэд хог хаягдлын тухай мэдлэгийг нэмэгдүүлдэг	.672			
	Аялал жуулчлалыг дагаж хяналтгүй олон салаа замууд бий болж хөрсийг доройтуулдаг	.666			
	Аялал жуулчлал нь хог хаягдлыг нэмэгдүүлдэг	.656			
	Аялал жуулчлал нь жуулчид, орон нутгийн иргэдийн эко мэдлэгийг нэмэгдүүлдэг	.651			
	Аялал жуулчлал нь байгалийн унаган төрхийг доройтуулдаг	.648			
	Аялал жуулчлалыг дагаж байгаль хамгааллын үйл ажиллагаа сайжирдаг	.631			
	Аялал жуулчлалыг дагаж хуванцар болон нийлэг материалын хэрэглээ өсдөг	.628			
	Аялал жуулчлалыг дагаж байгаль хамгаалах нөхөрлөл, бүлгийн үйл ажиллагаа сайжирдаг	.613			
	Аялал жуулчлалыг дагаж зэрлэг ан амьтан болон ургамал хамгаалал, бүртгэлжүүлэлт сайжирдаг	.609			

Төр, захиргааны үйл ажиллагааны өөрчлөлтүүд	Аялал жуулчлалыг дагаж төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаа сайжирдаг	.754	1.729	4.322	.889
	Аялал жуулчлалыг дагаж салбар дундын уялдаа холбоо сайжирдаг	.744			
	Аялал жуулчлалыг дагаж иргэдийн нийгмийн идэвх, оролцоо нэмэгддэг	.740			
	Аялал жуулчлалыг дагаж хөгжлийн бодлого боловсруулах, төлөвлөх үйл ажиллагаа сайжирдаг	.737			
	Төр, захиргааны бүтэц, хүний нөөцийн өөрчлөлт нь аялал жуулчлалын бодлого, стратегийн хэрэгжилтэд саад учруулдаг	.704			
	Аялал жуулчлал нь орон нутгийн төрийн бус байгууллагуудыг дэмждэг	.700			
	Аялал жуулчлалын эмх замбраагүй байдал нь төр, захиргааны ажлын ачааллыг нэмэгдүүлдэг	.693			
	Алсын хараагүй бодлого, төлөвлөлт нь аялал жуулчлалын үйл ажиллагааг доголдуулдаг	.687			
	Аялал жуулчлалыг дагаж төр, захиргааны хүнд суртал нэмэгддэг	.668			
	Аялал жуулчлалыг дагаж авилга, хээл хахуулийн гэмт хэрэг нэмэгддэг	.662			
Бодит гүйцэтгэлийн хувь 57.212 KMO = .961 Bartlett's test X=109687.378 (df=780, sig=.000)					

Эх сурвалж: Судалгааны үр дүн

3.4 Аялал жуулчлалын эерэг ба сөрөг нөлөөллийн тухай ойлголтын зөрүү

Иргэдийн аялал жуулчлалын нөлөөллийн тухай ойлголтыг эерэг болон сөрөг гэсэн 2 бүлэгт хуваан, хувьсагчдын хувьд ялгаатай үзүүлэлт байгаа эсэхийг хоёр үл хамаарсан түүврийн t шалгуураар хийж Хүснэгт 7-д харууллаа.

Иргэд «Байгаль орчны өөрчлөлтүүд»-ийн сөрөг нөлөөлөлийг эерэг нөлөөлөлөөс илүү мэддэг гэж үнэлгээ өгсөн байна. Харин «Эдийн засгийн өөрчлөлтүүд», «Нийгэм, соёлын өөрчлөлтүүд», «Төр, захиргааны үйл ажиллагааны өөрчлөлтүүд»-ийн эерэг нөлөөлөлийг сөрөг нөлөөлөлөөс илүү мэддэг гэсэн үнэлгээг тус тус өгсөн байна.

Хүснэгт 7. Хоёр үл хамаарсан түүврийн t шалгуурын үр дүн (бүх аймгаар)

	Эерэг нөлөөлөл		Сөрөг нөлөөлөл		Difference (Эерэг-Сөрөг)	t value	p value
	Mean	St dev	Mean	St dev			
Эдийн засгийн өөрчлөлтүүд	3.37	.957	2.83	.966	.577	35.405	**
Нийгэм, соёлын өөрчлөлтүүд	3.52	.915	2.81	.974	.738	42.055	**
Байгаль орчны өөрчлөлтүүд	3.10	.965	3.27	1.012	-.134	-9.194	**
Төр, захиргааны үйл ажиллагааны өөрчлөлтүүд	3.04	.979	2.69	1.034	.387	22.658	**

Эх сурвалж: Судалгааны үр дүн

* $p < 0.05$ ** $p < 0.01$

Мөн тухайн аймаг тус бүрийн дэлгэрэнгүйг Хавсралт-д үзүүлсэн бөгөөд зарим онцлогийг дурьдвал, 11 аймгийн хувьд (Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дундговь, Өмнөговь, Төв, Увс, Хэнтий) байгаль орчны эерэг болон сөрөг ойлголтын мэдлэг зөрүү байхгүй буюу ижил түвшинд мэднэ хэмээн хариулсан байна. Энэ нь аялал жуулчлалын нөлөөллийг байгаль орчны өөрчлөлтөөр их мэдэж байна гэсэн үг юм. Мөн Төр, захиргааны үйл ажиллагааны өөрчлөлтүүдийн эерэг болон сөрөг ойлголтын зөрүүгүй хэмээн Дорнод болон Төв аймгийн оролцогсод, Эдийн засгийн өөрчлөлтүүдийн эерэг болон сөрөг ойлголтын зөрүү байхгүй хэмээн Дорнод аймгийн оролцогсод хариулсан болохыг тухайн аймгийн хоёр үл хамаарсан түүврийн t шалгуурын үр дүнгээс харж болно.



3.5 Аялал жуулчлалын өөрчлөлтүүдийн хоорондын хамаарал

Хүснэгт 8-д хүчин зүйлийн хоорондын хамаарлыг тогтоох зорилгоор корреляцийн шинжилгээг хийж үр дүнг үзүүлсэн.

Аялал жуулчлалын нөлөөлөл бүхий өөрчлөлтүүдийг илэрхийлсэн хувьсагчид хоорондоо эерэг бөгөөд сайн хамааралтай ($r = 0.637-0.728$, $N = 4415$, $p < 0.01$) гарчээ. Өөрөөр хэлбэл аялал жуулчлалын нөлөөгөөр тухайн аймагт эдийн засаг 1 пунктээр өөрчлөгдөхөд нийгэм соёл 72.8%, байгаль орчин 63.9%, төр, захиргааны үйл ажиллагаа 64.7%-иар өөрчлөлт ордог гэсэн үзүүлэлт гарсан байна.

Аймаг тус бүрийн үзүүлэлтийг Хавсралт-д дэлгэрэнгүй харуулсан ба зарим үзүүлэлтийг онцолбол:

Хамгийн хүчтэй эерэг хамаарал Увс аймагт Нийгэм, соёлын өөрчлөлтүүд ба Байгаль орчны өөрчлөлтүүдийн хамаарал ($r = 0.1000$), Орхон аймагт Байгаль орчны өөрчлөлтүүд ба Төр, захиргааны үйл ажиллагааны өөрчлөлтүүдийн хамаарал ($r = 0.800$) хэмээн гарчээ. Хамгийн сул эерэг хамааралтай нь Говь-Алтай аймагт Нийгэм, соёлын өөрчлөлтүүд ба Төр, захиргааны үйл ажиллагааны өөрчлөлтүүдийн хамаарал ($r = 0.382$), Өвөрхангай аймагт Эдийн засгийн өөрчлөлтүүд ба Байгаль орчны өөрчлөлтүүдийн хамаарал ($r = 0.371$) тус тус гарсан байна.

Хүснэгт 8. Корреляцийн шинжилгээний үр дүн (бүх аймгаар)

	1	2	3	4
Эдийн засгийн өөрчлөлтүүд (1)	1			
Нийгэм, соёлын өөрчлөлтүүд (2)	.728**	1		
Байгаль орчны өөрчлөлтүүд (3)	.639**	.721**	1	
Төр, захиргааны үйл ажиллагааны өөрчлөлтүүд (4)	.647**	.637**	.675**	1

Эх сурвалж: Судалгааны үр дүн

* $p < 0.05$ ** $p < 0.01$

3.6 Дүгнэлт

Аялал жуулчлалын тогтвортой хөгжлийг хангах гол түлхүүр элементүүдийн нэг болох орон нутгийн иргэдийн аялал жуулчлалын талаарх мэдлэг, ойлголтыг тодорхойлох зорилгоор 21 аймгийн 4415 иргэдийн санал бодлыг судлан, дараах судалгааны дүгнэлтийг хийлээ.

Уг судалгаанд оролцсон иргэдийн бизнесийн үйл ажиллагаа аялал жуулчлалтай дам болон шууд хамааралтай байсан ба үйлдвэрлэл эрхлэгч,

үйлчилгээ эрхлэгч, төрийн албан хаагчдын оролцоо жигд байсан. Мөн 63.8 хувь нь тухайн орон нутагтаа 16-с дээш жил амьдарч буй иргэд хамрагдсан нь судалгаа зорилтот бүлэгтээ хүрч чадсан гэж үзэж байна.

Хүчин зүйлийн болон найдвартай байдлын шинжилгээгээр “Эдийн засгийн өөрчлөлтүүд”-ийн 10 асуулт, “Нийгэм, соёлын өөрчлөлтүүд”-ийн 10 асуулт, “Байгаль орчны өөрчлөлтүүд”-ийн 10 асуулт, “Төр, захиргааны үйл ажиллагааны өөрчлөлтүүд”-ийн 10 асуулт, нийт 4 бүлэг 40 асуулгаар судалгааг авч боловсруулалт хийх нь үндэслэлтэй бөгөөд найдвартай гэж үзсэн. Иймд дараа дараагийн шинжилгээнүүдийг уг 4 хувьсагчаар хийж, тооцоололыг гаргасан.

Энэхүү судалгааны хувьд орон нутгийн иргэдийн өгсөн үнэлгээгээр “Байгаль орчны өөрчлөлт”-ийн дундаж утга 3.18 буюу бусад хувьсагчдаас өндөр үнэлгээтэй гарсан. Аялал жуулчлал нь жуулчид, орон нутгийн иргэдэд хог хаягдлын (3.26) болон эко мэдлэгийг нэмэгдүүлдэг (3.17) гэсэн байгаа нь судлаач Аны судалгааны байгаль орчны бүлэгт хамаарах Аялал жуулчлалыг дагаж байгаль орчны эерэг хандлага, ёс зүй бий болно гэх үр дүнтэй нийцэж байна.³⁵ Мөн цаашилбал Кошхам нарын (2016) судалгаагаар аялал жуулчлал нь байгаль орчныг хамгаалах боловсролыг нэмэгдүүлдэг гэсэнтэй санал нийлж байгаа боловч Хонг Вү нарын (2020) судалгааны үр дүн болох иргэд харьцангуй байгаль орчны өөрчлөлтийг эерэгээр харж байна гэсэнтэй нийцээгүй буюу эсрэг утга гарсан.³⁶ Учир нь сөрөг нөлөөллийн дундаж утга 3.27 байгаа нь эерэг утгаас өндөр байгаа бөгөөд энэ нь иргэд аялал жуулчлалыг дагаж байгаль орчин доройтож байна гэж үзэж байна. Аялал жуулчлал нь хог хаягдлыг нэмэгдүүлдэг ($m=3.40$), Аялал жуулчлалыг дагаж хяналтгүй олон салаа замууд бий болж хөрсийг доройтуулдаг ($m=3.37$), Аялал жуулчлалыг дагаж хуванцар болон нийлэг материалын хэрэглээ өсдөг ($m=3.37$) гэж үзэж байна. Орон нутгийн иргэд аялал жуулчлалын хөгжлийг дагасан сөрөг нөлөөлөл ихтэй байна гэж үзэх тусам аялал жуулчлалын хөгжлийн хөтөлбөрт оролцох нийгмийн хандлагыг бууруулдаг тул орон нутагт хэрэгжүүлж буй байгаль орчныг хамгаалах олон улсын болоод дотоодын хөтөлбөр, сургалт, арга хэмжээний мэдээллийг хүртээмжтэй хүргэх тэдний оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай байна. Хувьсагчидын хувьд эерэг болон сөрөг ойлголтын ялгаатай байдлыг илрүүлэх шинжилгээгээр байгаль орчны эерэг ойлголт сөргөөсөө бага үзүүлэлттэй, хоорондын хамаарлын шинжилгээгээр байгаль орчны өөрчлөлт нь бусад хувьсагчидтайгаа эерэг бөгөөд сайн хамааралтай гэсэн үр дүнтэй гарчээ.

³⁵ An, Y. (2016). Resident's Perception of Tourism Development in Greenville, SC, USA. All Theses, 2418.

³⁶ Hong Wu, Seongseop (Sam) Kim, & Antony King Fung Wo. (2020). Residents' perceptions of desired and perceived tourism impact in Hainan Island. Asia Pacific Journal of Tourism Research, 583-601.



“Нийгэм, соёлын өөрчлөлтүүд”-ийн хувьсагчийн дундаж утга 3.16 үнэлгээтэй гарсан. Ким болон Жун нар (2015) ын судалгаагаар аялал жуулчлалын хөгжил нь орон нутгийн байгалийн үзэмжит газрын нэр хүндийг өсгөдөг, шинэ мэдлэг, соёлын хэрэглээ үүсдэг, ундны ус, эрчим хүч, зорчигч тээвэр, зам харилцааны дэд бүтэц сайжирдаг зэргийг хүлээн зөвшөөрч байгаа нь нутгийн иргэд орон нутгаараа бахархах сэтгэгдлийг бий болгож байгааг баталсан.³⁷ Энэ нь мөн манай судалгааны үр дүнтэй нийцэж эерэг нөлөөллийн дундаж утга $m=3.52$ гарсан. Хамгийн өндөр дундаж утга бүхий аялал жуулчлал нь орон нутгийн байгалийн үзэмжит газрын нэр хүндийг өсгөдөг ($m=3.66$), түүх, соёлын өвийн мэдлэг, ашиглалтыг сайжруулдаг ($m=3.66$), гэж нутгийн иргэд хүлээн зөвшөөрч байна. Судлаач Доганы (1989) судалгаагаар аялал жуулчлал хөгжсөн хөгжингүй орнуудад уламжлалт ёс заншилаа үгүйсгэх, гэмт хэргийн гаралт нэмэгдэх болон нийгэм соёлын бүтэц ерөнхий байдлыг гажуудуулдаг гэдгийг баталсан³⁸ байсныг Хуанг болон Стюарт нар (1996) онд ахин баталжээ.³⁹ Манай судалгааны хувьд аялал жуулчлал хөгжсөнөөр нийгэм соёлын орчинд үүсэх сөрөг нөлөөллийн дундаж утга $m=2.81$ гарсан нь иргэд сөрөг нөлөөллийг эерэг нөлөөллөөсөө бага гэж үзэж байна. Тиймээс орон нутгийн аялал жуулчлалын хөтөлбөр боловсруулагч, төлөвлөгч удирдлагууд үүсэж болох сөрөг нөлөөллийг урт хугацаандаа хамгийн бага байлгах тал дээр анхаарч энэ чиглэлийн сургалт, олон нийтийн ажлыг зохион байгуулдаг байх нь иргэдийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд тусална. Орон нутгийн иргэдийн дэмжлэг нь аялал жуулчлалын тогтвортой хөгжилд гол тулгуур болдог⁴⁰ зочломтгой аялал жуулчлалыг бий болгодог⁴¹ болохыг тус тус баталсан байдаг. Тэгвэл манай судалгааны хувьд иргэд сөрөг нөлөөллийн хэсэгт хамгийн бага үнэлгээг аялал жуулчлал нь иргэдийн амар тайван байдлыг алдагдуулдаг гэж үзсэн нь орон нутагт аялал жуулчлалыг хөгжүүлэхэд иргэдээс дэмжлэг авахад таатай нөхцөл болж чадах юм. Хувьсагчидын хувьд эерэг болон сөрөг ойлголтын ялгаатай байдлыг илрүүлэх шинжилгээгээр нийгэм соёлын эерэг ойлголт сөргөөсөө илүү үзүүлэлттэй, хоорондын хамаарлын шинжилгээгээр нийгэм соёлын өөрчлөлт нь бусад хувьсагчидтайгаа эерэг бөгөөд сайн хамааралтай гэсэн үр дүнтэй гарчээ.

³⁷ Kim, W., Jun, H., & Walker, M. (2015). Evaluating the perceived social impacts of hosting large-scale sport tourism events. *Tourism Management*, 21-32.

³⁸ Dogan, H. (1989). *Formsof Adjustment: Socio Cultural Impacts of Tourism*. *Tourism Research*, 216-236.

³⁹ Huang, Y., & Stewart, W. (1996). Rural tourism development: Shifting basis of community solidarity. *Journal of Travel Research*, 26-32.

⁴⁰ Jurowski, C., Uysal, M., & D.R. Williams. (1997). A Theoretical Analysis of Host Community Resident Reaction to Tourism. *Journal of Travel Research*, 3-11.

⁴¹ Coccossis, H., & A. Parpairis. (1992). Assessing the interaction between Environment and Tourism: Case study of the island of Myconos. Paper. Congress of the IRSA Palma de Mallorca. Paper presented at the IV World Congress of the IRSA Palma de Mallorca. the IV World.

Судалгааны “Эдийн засгийн өөрчлөлтүүд”-ийн дундаж утга 3.10 гарсан. Озгүр (1985) нарын судалгаагаар нутгийн иргэд аялал жуулчлалын эдийн засгийн нөлөөллийг илүүтэй мэддэг болох нь батлагдсан бол манай судалгааны үр дүнд эдийн засгийн нөлөөлөл нь байгаль орчин болон нийгмийн нөлөөллийн дараагаар эрэмбэлэгдлээ.⁴² Жиасио (2018) нарын болон Кроесийн (2014) судалгаанд оролцогчид эдийн засгийн эерэг нөлөөллийн талаарх ойлголтыг голлох үзүүлэлт болгож байна.⁴³ Энэ үр дүнг нь манай судалгаагаар мөн адил эерэг нөлөөллийн ойлголт нь сөрөг нөлөөллийн ойлголтоосоо өндөр буюу 3.38 гэсэн дундаж утгатайгаар батлагдаж байна. Мөн бидний судалгааны үр дүнд эдийн засгийн эерэг нөлөөллийн хамгийн өндөр үзүүлэлтийг орон нутгийн худалдаа, үйлчилгээг идэвхжүүлдэг ($m=3.53$), үүнийг дагасан ажлын байр нэмэгдүүлдэг ($m=3.42$) гэсэн байна. Тиймээс нутгийн иргэд аялал жуулчлалыг дотоодын бизнесийг хөгжүүлэх, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх боломжтой салбар гэж хүлээн зөвшөөрч байна.⁴⁴ Аялал жуулчлалыг дагаж бизнесийн шинэ төрлүүд нэмэгддэг гэсэн ойлголт нь өндөр үнэлгээтэй ($m=3.42$) гарсан ба энэ судлаач Жиасио нарын судалгааны адилаар жижиг дунд бизнесийн боломжийг нэмэгдүүлдэг гэдэг үр дүнтэй адил гарчээ.⁴⁵ Эдийн засгийн сөрөг нөлөөллийн ойлголтоос хамгийн өндөр үзүүлэлтийг үнэ тарифын ($m=3.10$) болон үл хөдлөхийн үнийн өсөлт хөөрөгдөл ($m=3.0$) гэсэн ойлголт нь Лиү Ли нарын судалгааны үр дүнтэй ижил байна.⁴⁶ Мөн түүнчлэн улирлын чанартайгаар бизнесүүд тогтворгүйжих,⁴⁷ орлогын ялгаатай байдал үүсэх⁴⁸ гэх мэт сөрөг нөлөөллүүд үүсдэг болдог нь улирлаас хамаарч ажилгүй иргэдийн тоо өсдөг, татвар, торгуулийн дарамт нэмэгддэг, ажиллах хүчний хомдол үүсдгийг анхаарах хэрэгтэй байна. Аялал жуулчлалын оргил ачааллын үеэр нутгийн иргэд газар тарилан, мал аж ахуйн салбарт ажиллах хэрэгцээ үүсдэг нь аялал жуулчлалын салбарт ажиллах хүчний тоог бууруулж нэмэлт орлого олох боломжийг бүрэн ашиглаж чадахгүй байна. Энэ талаарх ойлголтыг ($m=2.52$) нутгийн иргэдэд цаашид ойлгуулах шаардлага үүсч байна. Хувьсагчидын хувьд эерэг болон сөрөг ойлголтын ялгаатай байдлыг илрүүлэх шинжилгээгээр эдийн засгийн эерэг ойлголт сөргөөсөө илүү үзүүлэлттэй, хоорондын хамаарлын шинжилгээгээр эдийн засгийн өөрчлөлт нь бусад хувьсагчидтайгаа эерэг бөгөөд сайн хамааралтай гэсэн үр дүнтэй гарчээ.

⁴² Özgür, H., Tatoğlu, E., Erdal, U., & Azakli, S. (1985). Resident perceptions of the impact of tourism in a Turkish resort town. *Annals of Tourism Research*, 652-658.

⁴³ Croes. (2014). The role of tourism in poverty reduction: An empirical assessment. *Tourism Economics*, 207-226.

⁴⁴ Giaccio, Giannelli, & Mastronardi. (2018). Explaining determinants of agri-tourism income: Evidence from Italy. *Tourism Review*, 216-229.

⁴⁵ Giaccio, Giannelli, & Mastronardi. (2018). Explaining determinants of agri-tourism income: Evidence from Italy. *Tourism Review*, 216-229.

⁴⁶ Liu, X., & Li, J. (2018). Host perceptions of tourism impact and stage of destination development in a developing country. *Sustainability*, 2300.

⁴⁷ Duro, J., & Turrión-Prats, J. (2019). Tourism seasonality world-wide. *Tourism Management Perspectives*, *Tourism Management Perspectives*, 38-53.

⁴⁸ Alam, M., & Paramati, S. (n.d.). The impact of tourism on income inequality in developing economies: Does Kuznets curve hypothesis exist? *Annals of Tourism Research*, 111-126.



“Төр, захиргааны үйл ажиллагааны өөрчлөлтүүд”-ийн ерөнхий дундаж утга $m=2.86$ байгаа нь иргэдийн мэдлэг хангалтгүй байна гэсэн дүгнэлтэд хүргэлээ. Улс төрийн нөлөөлөл нь эдийн засаг, нийгэм соёлын орчны нөлөөлөлтэй ижил үр дүнд хүрсэн бөгөөд нутгийн иргэд улс төрийн сөрөг нөлөөллөөс ($m=2.69$) илүү эерэг нөлөөллийн ($m=3.04$) талаар илүү өндөр түвшинд мэдэж байна. Энэ талаарх сөрөг нөлөөллийн дундаж утга 2.69 гарч иргэдийн нилээдгүй хувь нь төр захиргааны үйл ажиллагааны талаар мэдэхгүй гэж хариулж байгаа нь мэдээлэл, оролцоо хангалтгүй байгааг харуулж байна. Орон нутгийн удирдлагууд болон аялал жуулчлалын хөгжлийн төлөвлөгөө боловсруулагчид аялал жуулчлалын нөөцийг төлөвлөх, хамгаалах талаар олон нийт, төр захиргааны үйл ажиллагааны талаарх мэдээллийг дээшлүүлэхийн тулд нутгийн иргэд, жуулчид, үйлчилгээний байгууллага болон бусад оролцогч талуудад боловсролыг нэмэгдүүлэх мэдээлэл, хөтөлбөрүүдээр (жишээ нь сургалт, семинар) хангах шаардлагатай байдаг.⁴⁹ Тэдгээр оролцогч талууд нь зорин очих газрын менежментийн төлөвлөгөөнд хяналт тавих, засварлах, өөрчлөлт оруулах зэрэг системийг хамтдаа хөгжүүлдэг. Хувьсагчидын хувьд эерэг болон сөрөг ойлголтын ялгаатай байдлыг илрүүлэх шинжилгээгээр улс төрийн эерэг ойлголт сөргөөсөө бага үзүүлэлттэй, хоорондын хамаарлын шинжилгээгээр улс төрийн өөрчлөлт нь бусад хувьсагчидтайгаа эерэг бөгөөд сайн хамааралтай гэсэн үр дүнтэй гарчээ.

Аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэхийн тулд нутгийн иргэдийн мэдлэг, ойлголтыг дэлгэрүүлэн судалж аялал жуулчлалын хөгжлийн хөтөлбөрт тэдний бодол, саналыг тусган оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай.⁵⁰ Аялал жуулчлалын хөгжлийн төлөвлөгөө боловсруулагч орон нутгийн удирдлага нь иргэд эдийн засгийн хувьд өгөөжтэй байлгах харин нөгөө талдаа аялал жуулчлал нь орон нутгийн иргэдийн нийгэм соёл болоод байгаль орчинд сөрөг нөлөөг үзүүлэхгүй байх тал дээр анхаарч хөтөлбөр, арга хэмжээг төлөвлөн, зохион байгуулах шаардлагатай.⁵¹ Жуулчдыг хүлээн авч буй нутгийн иргэд аз жаргалтай байх тусам таатай орчин бүрдүүлж давтан ирэх жуулчидын тоо өсөх, ам дамжсан маркетингийг хийдэг⁵² тул аялал жуулчлалыг тухайн бүс нутагт хөгжүүлэхийн тулд иргэдийн таатай орчинд амьдрах нөхцлийг нэн тэргүүнд анхаарах шаардлагатай болно. Тиймээс цаашид дэлгэрэнгүй судалгаагаар тухайн нутгийн иргэдийн аз жаргалын индексийг тодорхойлж бүс нутгийн онцлогт тохирсон компани ажлыг төлөвлөн хэрэгжүүлэх суурь судалгааг хийх шаардлага үүсч байна.

⁴⁹ Sirakaya, Jamal, & Choi. (2001). Developing tourism indicators for destination sustainability. The encyclopedia of ecotourism, 411-432.

⁵⁰ Yu WANG, Gang LI, & Xuemei BAI. (2005). A Residential Survey on Urban Tourism Impacts in Harbin. China Tourism Research, 116-129.

⁵¹ An, Y. (2016). Resident's Perception of Tourism Development in Greenville, SC, USA. All Theses, 2418.

⁵² LeBlanc, G. (1992). Factors Affecting Customer Evaluations of Service Quality in Travel Agencies: An Investigation of Customer Perspectives. Journal of Travel Research, 10-16.

3.7 Зөвлөмж

Ийнхүү өмнөх судлаачдын судалгааны үр дүн, дүгнэлт болон уг судалгааны өгөгдөл боловсруулалтын үр дүнд тулгуурлан аймаг тус бүрт үнэлгээ өгч, зөвлөмж боловсруулах нэгдсэн матрицийг боловсруулав. Энэхүү зөвлөмжид дурьдсан сургалтыг модуль хэлбэрээр зохион байгуулах нь тохиромжтой. Иргэдийн аялал жуулчлалын талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх сургалтын үйл ажиллагааг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран үе шаттайгаар зохион байгуулахыг санал болгож байна.

Хүснэгт 9. Зөвлөмж боловсруулах матриц

№	Асуулга	Зорилго	Үзүүлэлт	Шатлал	Үнэлгээ	Зөвлөмж
1	Тухайн аймагтаа оршин сууж байгаа жил (Асуулга 2)	Тогтвор суурьшил	1-5 жил	Судалгаанд оролцогсдын 50-с дээш %	Шинэ оршин суугч	Зорилтот бүлгийн мэдээлэн тайлбарлах сургалт (чиглүүлэх сургалт)
			6-с дээш жил	Судалгаанд оролцогсдын 50-с дээш %	Уугуул оршин суугч	Үйлчилгээний бизнес эрхлэх хандлагыг өөрчлөх нөлөөллийн сургалт
2	Нас (Асуулга 3)	Насны бүлэг	55 хүртэлх	Судалгаанд оролцогсдын 50-с дээш %	Идэвхтэй	Идэвхтэй арга барилаар мэдлэг дадлыг эзэмшүүлэх (жишээ нь: социал орчин)
			55-с дээш нас	Судалгаанд оролцогсдын 50-с дээш %	Идэвхгүй	Хөндлөнгийн оролцоогоор хангах (жишээ нь: сайн дурын ажил)



3	Эрхэлж буй ажил, бизнес аялал жуулчлалтай хамааралтай эсэх (Асуулга 6)	Бизнесийн уялдаа	Огт хамааралгүй	Судалгаанд оролцогсдын 33-с дээш %	Огт уялдаагүй	Үйлчилгээний бизнесийн сургалт
			Дам хамааралтай	Судалгаанд оролцогсдын 33-с дээш %	Уялдаатай	Түншлэлийн зан төлвийн сургалт
			Шууд хамааралтай	Судалгаанд оролцогсдын 33-с дээш %	Нарийн уялдаатай	Үйлчилгээний дизайны сургалт
4	Аялал жуулчлалын нөлөөллийн үнэлгээ (Асуулга 7-10)	Мэдлэг ойлголтын түвшин	0.00-1.66	Судалгаанд оролцогсдын 33-с дээш %	Бага мэдлэгтэй	Тухайн чиглэлийн мэдээлэн тайлбарлах сургалт (жишээ нь: чиглүүлэх сургалт)
			1.67-3.34	Судалгаанд оролцогсдын 33-с дээш %	Дундаж мэдлэгтэй	Тухайн чиглэлийн суурь мэдлэг олгох сургалт (жишээ нь: төрөлжсөн сургалт)
			3.35-5.00	Судалгаанд оролцогсдын 33-с дээш %	Сайн мэдлэгтэй	Тухайн чиглэлийн ур чадварын сургалт (жишээ нь: практик сургалт)
	4.1	Эдийн засгийн өөрчлөлтүүд				
4.2	Нийгэм, соёлын өөрчлөлтүүд					
4.3	Байгаль орчны өөрчлөлтүүд					
4.4	Төр, захиргааны үйл ажиллагааны өөрчлөлтүүд					

5	Аялал жуулчлалын нөлөөллийн үнэлгээ (Асуулга 7-10)	Аялал жуулчлалын нөлөөллийн эерэг ба сөрөг ойлголтын зөрүү	t value +1<	Нэмэх утга	Эерэг ойлголт давамгайлсан	Тухайн чиглэлийн сөрөг нөлөөллийг тодруулах сургалт (жишээ нь: мониторинг, аудит)
			t value -1<	Хасах утга	Сөрөг ойлголт давамгайлсан	Тухайн чиглэлийн эерэг хандлага, мэдлэг чадварын манлайлалын сургалт (жишээ нь: шилдэг туршлага)
			p value p<0.1	Ач холбогдлын түвшингүй	Зөрүү байхгүй	Тухайн чиглэлийн тогтвортой байдлын сургалт (жишээ нь: эрсдлийн үнэлгээ)
	5.1	Эдийн засгийн өөрчлөлтүүд				
5.2	Нийгэм, соёлын өөрчлөлтүүд					
5.3	Байгаль орчны өөрчлөлтүүд					
5.4	Төр, захиргааны үйл ажиллагааны өөрчлөлтүүд					



6	Аялал жуулчлалын нөлөөллийн үнэлгээ (Асуулга 7-10)	Аялал жуулчлалын нөлөөллүүдийн хоорондын хамаарал	$r = 0.701 - 1.000$	Хүчтэй эерэг хамааралтай	Өндөр эрчимтэй	Салбар дундын үнэ цэнийн сүлжээний тойм сургалт (жишээ нь: чиглүүлэх сургалт)
			$r = 0.301 - 0.700$	Дунд зэрэг эерэг хамааралтай	Эрчимтэй	Салбар дундын зохицуулалтын тойм сургалт (жишээ нь: чиглүүлэх сургалт)
			$r = 0 - 0.300$	Сул эерэг хамааралтай	Эрчим багатай	Салбар дундын хамтын ажиллагааны тойм сургалт (жишээ нь: чиглүүлэх сургалт)
	6.1	Эдийн засгийн өөрчлөлтүүд ↔ Нийгэм, соёлын өөрчлөлтүүд				
6.2	Эдийн засгийн өөрчлөлтүүд ↔ Байгаль орчны өөрчлөлтүүд					
6.3	Эдийн засгийн өөрчлөлтүүд ↔ Төр, захиргааны үйл ажиллагааны өөрчлөлтүүд					
6.4	Нийгэм, соёлын өөрчлөлтүүд ↔ Байгаль орчны өөрчлөлтүүд					
6.5	Нийгэм, соёлын өөрчлөлтүүд ↔ Төр, захиргааны үйл ажиллагааны өөрчлөлтүүд					
6.6	Байгаль орчны өөрчлөлтүүд ↔ Төр, захиргааны үйл ажиллагааны өөрчлөлтүүд					
7	Онцлох үзүүлэлт	Хамгийн хүчтэй үзүүлэлт				
		Хамгийн сул үзүүлэлт				

БҮЛЭГ 4. АЙМГУУДЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮНГИЙН НЭГТГЭЛ, ЗӨВЛӨМЖ

4.1 Архангай аймаг

Архангай аймгаас судалгаанд оролцсон 600 иргэдийн эмэгтэй 53.8 %, 25-34 насныхан 51.5 %, төрийн албан хаагч 45.5 %, аймагтаа 20-с дээш жил амьдарч буй иргэд 35.2 %, эрхэлж буй ажил бизнес нь аялал жуулчлалын үйл ажиллагаатай дам хамааралтай иргэд 38.0 % тус тус харьцангуй өндөр хувь эзэлж байна.

Иргэдийн өгсөн үнэлгээгээр “Эдийн засгийн өөрчлөлтүүд”-ийн дундаж утга 3.39, «Нийгэм, соёлын өөрчлөлтүүд»-ийн дундаж утга 3.40, «Байгаль орчны өөрчлөлтүүд»-ийн дундаж утга 3.41, «Төр, захиргааны үйл ажиллагааны өөрчлөлтүүд»-ийн дундаж утга 3.12 тус тус гарсан.


Хувьсагчдын эерэг болон сөрөг ойлголтын ялгаатай байдлыг илрүүлэх шинжилгээгээр байгаль орчны эерэг ойлголт сөргөөсөө бага үзүүлэлттэй, бусад хувьсагчдын хувьд эерэг ойлголт давамгайлсан үнэлгээтэй байна.

Хувьсагчдын хоорондын хамаарлын шинжилгээгээр бүх хувьсагчид хоорондоо эерэг бөгөөд сайн хамааралтай гэсэн үр дүнтэй гарчээ.

Хамгийн хүчтэй үзүүлэлт «Аялал жуулчлал нь шашин, урлаг, соёлын арга хэмжээг нэмэгдүүлдэг» дундаж утга 3.74, хамгийн сул үзүүлэлт «Төр, захиргааны бүтэц, хүний нөөцийн өөрчлөлт нь аялал жуулчлалын бодлого, стратегийн хэрэгжилтэд саад учруулдаг» дундаж утга 2.76 тус тус гарсан.

Архангай аймгийн иргэдийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн ур чадварын сургалт; тухайн чиглэлийн суурь мэдлэг олгох сургалт; сөрөг нөлөөллийг тодруулах сургалт; эерэг хандлага, мэдлэг чадварын манлайлалын сургалт; салбар дундын зохицуулалтын тойм сургалт зэргийг санал болгосон.

Зураг 2. Архангай аймгийн иргэдийн мэдлэг, ойлголтын ерөнхий үнэлгээ



Хүснэгт 10. ЗӨВЛӨМЖ: Архангай аймаг

№	Зорилго	Үзүүлэлт	Аймгийн үр дүн	Үнэлгээ	Зөвлөмж
1	Тогтвор суурьшил	6-с дээш жил	91.8 %	Уугуул оршин суугч	Үйлчилгээний бизнес эрхлэх хандлагыг өөрчлөх нөлөөллийн сургалт
2	Насны бүлэг	55 хүртэлх	88.7 %	Идэвхтэй	Идэвхтэй арга барилаар мэдлэг дадлыг эзэмшүүлэх (жишээ нь: социал орчин)
3	Бизнесийн уялдаа	Дам хамааралтай	38.0 %	Уялдаатай	Түншлэлийн зан төлвийн сургалт
		Шууд хамааралтай	35.3 %	Нарийн уялдаатай	Үйлчилгээний дизайны сургалт
4. Мэдлэг ойлголтын түвшин					
4.1	Эдийн засгийн өөрчлөлтүүд	3.35-5.00	3.39	Сайн мэдлэгтэй	Тухайн чиглэлийн ур чадварын сургалт (жишээ нь: практик сургалт)
4.2	Нийгэм, соёлын өөрчлөлтүүд	3.35-5.00	3.40	Сайн мэдлэгтэй	Тухайн чиглэлийн ур чадварын сургалт (жишээ нь: практик сургалт)

4.3	Байгаль орчны өөрчлөлтүүд	3.35-5.00	3.41	Сайн мэдлэгтэй	Тухайн чиглэлийн ур чадварын сургалт (жишээ нь: практик сургалт)
4.4	Төр, захиргааны үйл ажиллагааны өөрчлөлтүүд	1.67-3.34	3.12	Дундаж мэдлэгтэй	Тухайн чиглэлийн суурь мэдлэг олгох сургалт (жишээ нь: төрөлжсөн сургалт)
5. Аялал жуулчлалын нөлөөллийн эерэг ба сөрөг ойлголтын зөрүү					
5.1	Эдийн засгийн өөрчлөлтүүд	t value +1<	5.753	Эерэг ойлголт давамгайлсан	Тухайн чиглэлийн сөрөг нөлөөллийг тодруулах сургалт (жишээ нь: мониторинг, аудит)
5.2	Нийгэм, соёлын өөрчлөлтүүд	t value +1<	8.246	Эерэг ойлголт давамгайлсан	Тухайн чиглэлийн сөрөг нөлөөллийг тодруулах сургалт (жишээ нь: мониторинг, аудит)
5.3	Байгаль орчны өөрчлөлтүүд	t value -1<	-5.870	Сөрөг ойлголт давамгайлсан	Тухайн чиглэлийн эерэг хандлага, мэдлэг чадварын манлайлалын сургалт (жишээ нь: шилдэг туршлага)
5.4	Төр, захиргааны үйл ажиллагааны өөрчлөлтүүд	t value +1<	3.738	Эерэг ойлголт давамгайлсан	Тухайн чиглэлийн сөрөг нөлөөллийг тодруулах сургалт (жишээ нь: мониторинг, аудит)
6. Аялал жуулчлалын нөлөөллүүдийн хоорондын хамаарал					
6.1	Эдийн засгийн өөрчлөлтүүд <-> Нийгэм, соёлын өөрчлөлтүүд	r= 0.301-0.700	.655	Эрчимтэй	Салбар дундын зохицуулалтын тойм сургалт (жишээ нь: чиглүүлэх сургалт)
6.2	Эдийн засгийн өөрчлөлтүүд <-> Байгаль орчны өөрчлөлтүүд	r= 0.301-0.700	.545	Эрчимтэй	Салбар дундын зохицуулалтын тойм сургалт (жишээ нь: чиглүүлэх сургалт)
6.3	Эдийн засгийн өөрчлөлтүүд <-> Төр, захиргааны үйл ажиллагааны өөрчлөлтүүд	r= 0.301-0.700	.548	Эрчимтэй	Салбар дундын зохицуулалтын тойм сургалт (жишээ нь: чиглүүлэх сургалт)



6.4	Нийгэм, соёлын өөрчлөлтүүд (↔) Байгаль орчны өөрчлөлтүүд	$r = 0.301-0.700$.642	Эрчимтэй	Салбар дундын зохицуулалтын тойм сургалт (жишээ нь: чиглүүлэх сургалт)
6.5	Нийгэм, соёлын өөрчлөлтүүд (↔) Төр, захиргааны үйл ажиллагааны өөрчлөлтүүд	$r = 0.301-0.700$.556	Эрчимтэй	Салбар дундын зохицуулалтын тойм сургалт (жишээ нь: чиглүүлэх сургалт)
6.6	Байгаль орчны өөрчлөлтүүд (↔) Төр, захиргааны үйл ажиллагааны өөрчлөлтүүд	$r = 0.301-0.700$.600	Эрчимтэй	Салбар дундын зохицуулалтын тойм сургалт (жишээ нь: чиглүүлэх сургалт)
7	Онцлох үзүүлэлт	Хамгийн хүчтэй үзүүлэлт			
		Аялал жуулчлал нь шашин, урлаг, соёлын арга хэмжээг нэмэгдүүлдэг (3.74) Аялал жуулчлал нь түүх, соёлын өвийн мэдлэг, ашиглалтыг сайжруулдаг (3.71) Аялал жуулчлал нь байгалийн унаган төрхийг доройтуулдаг (3.7)			
		Хамгийн сул үзүүлэлт			
		Аялал жуулчлал нь орон нутгийн төрийн бус байгууллагуудыг дэмждэг (3.03) Аялал жуулчлалыг хөгжүүлснээр ХАА-н (газар тариалан, мал аж ахуй) ажиллах хүчний хомсдол үүсдэг (3.01) Төр, захиргааны бүтэц, хүний нөөцийн өөрчлөлт нь аялал жуулчлалын бодлого, стратегийн хэрэгжилтэд саад учруулдаг (2.76)			

4.2 Баян-Өлгий аймаг

Баян-Өлгий аймгаас судалгаанд оролцсон 125 иргэдийн эмэгтэй 50.4 %, 25-34 насныхан 34.4 %, бусад (малчин, тариаланч гэх мэт) 31.2 %, аймагтаа 20-с дээш жил амьдарч буй иргэд 54.4 %, эрхэлж буй ажил бизнес нь аялал жуулчлалын үйл ажиллагаатай огт хамааралгүй иргэд 45.6 % тус тус харьцангуй өндөр хувь эзэлж байна.

Иргэдийн өгсөн үнэлгээгээр “Эдийн засгийн өөрчлөлтүүд”-ийн дундаж утга 3.02, «Нийгэм, соёлын өөрчлөлтүүд»-ийн дундаж утга 3.16,

«Байгаль орчны өөрчлөлтүүд»-ийн дундаж утга 3.12, «Төр, захиргааны үйл ажиллагааны өөрчлөлтүүд»-ийн дундаж утга 2.98 тус тус гарсан.


Хувьсагчдын эерэг болон сөрөг ойлголтын ялгаатай байдлыг илрүүлэх шинжилгээгээр байгаль орчны ойлголт зөрүү байхгүй үзүүлэлттэй, бусад хувьсагчдын хувьд эерэг ойлголт давамгайлсан үнэлгээтэй байна.

Хувьсагчдын хоорондын хамаарлын шинжилгээгээр бүх хувьсагчид хоорондоо эерэг бөгөөд сайн хамааралтай гэсэн үр дүнтэй гарчээ.

Хамгийн хүчтэй үзүүлэлт «Аялал жуулчлал нь түүх, соёлын өвийн мэдлэг, ашиглалтыг сайжруулдаг» дундаж утга 3.56, хамгийн сул үзүүлэлт «Төр, захиргааны бүтэц, хүний нөөцийн өөрчлөлт нь аялал жуулчлалын бодлого, стратегийн хэрэгжилтэд саад учруулдаг» дундаж утга 2.56 тус тус гарсан.

Баян-Өлгий аймгийн иргэдийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйлчилгээний бизнесийн сургалт; тухайн чиглэлийн суурь мэдлэг олгох сургалт; сөрөг нөлөөллийг тодруулах сургалт; тухайн чиглэлийн тогтвортой байдлын сургалт; салбар дундын зохицуулалтын тойм сургалт зэргийг санал болгосон.

Зураг 3. Баян-Өлгий аймгийн иргэдийн мэдлэг, ойлголтын ерөнхий үнэлгээ





Хүснэгт 11. ЗӨВЛӨМЖ: Баян-Өлгий аймаг

№	Зорилго	Үзүүлэлт	Аймгийн үр дүн	Үнэлгээ	Зөвлөмж
1	Тогтвор суурьшил	6-с дээш жил	95.2 %	Уугуул оршин суугч	Үйлчилгээний бизнес эрхлэх хандлагыг өөрчлөх нөлөөллийн сургалт
2	Насны бүлэг	55 хүртэлх	92.8 %	Идэвхтэй	Идэвхтэй арга барилаар мэдлэг дадлыг эзэмшүүлэх (жишээ нь: социал орчин)
3	Бизнесийн уялдаа	Огт хамааралгүй	45.6 %	Огт уялдаагүй	Үйлчилгээний бизнесийн сургалт
		Шууд хамааралтай	35.3 %	Нарийн уялдаатай	Үйлчилгээний дизайны сургалт
4. Мэдлэг ойлголтын түвшин					
4.1	Эдийн засгийн өөрчлөлтүүд	1.67-3.34	3.02	Дундаж мэдлэгтэй	Тухайн чиглэлийн суурь мэдлэг олгох сургалт (жишээ нь: төрөлжсөн сургалт)
4.2	Нийгэм, соёлын өөрчлөлтүүд	1.67-3.34	3.16	Дундаж мэдлэгтэй	Тухайн чиглэлийн суурь мэдлэг олгох сургалт (жишээ нь: төрөлжсөн сургалт)
4.3	Байгаль орчны өөрчлөлтүүд	1.67-3.34	3.12	Дундаж мэдлэгтэй	Тухайн чиглэлийн суурь мэдлэг олгох сургалт (жишээ нь: төрөлжсөн сургалт)
4.4	Төр, захиргааны үйл ажиллагааны өөрчлөлтүүд	1.67-3.34	2.98	Дундаж мэдлэгтэй	Тухайн чиглэлийн суурь мэдлэг олгох сургалт (жишээ нь: төрөлжсөн сургалт)
5. Аялал жуулчлалын нөлөөллийн эерэг ба сөрөг ойлголтын зөрүү					
5.1	Эдийн засгийн өөрчлөлтүүд	t value +1<	2.950	Эерэг ойлголт давамгайлсан	Тухайн чиглэлийн сөрөг нөлөөллийг тодруулах сургалт (жишээ нь: мониторинг, аудит)
5.2	Нийгэм, соёлын өөрчлөлтүүд	t value +1<	6.592	Эерэг ойлголт давамгайлсан	Тухайн чиглэлийн сөрөг нөлөөллийг тодруулах сургалт (жишээ нь: мониторинг, аудит)

5.3	Байгаль орчны өөрчлөлтүүд	p value p<0.1		Зөрүү байхгүй	Тухайн чиглэлийн тогтвортой байдлын сургалт (жишээ нь: эрсдлийн үнэлгээ)
5.4	Төр, захиргааны үйл ажиллагааны өөрчлөлтүүд	t value +1<	5.588	Эерэг ойлголт давамгайлсан	Тухайн чиглэлийн сөрөг нөлөөллийг тодруулах сургалт (жишээ нь: мониторинг, аудит)
6. Аялал жуулчлалын нөлөөллүүдийн хоорондын хамаарал					
6.1	Эдийн засгийн өөрчлөлтүүд <-> Нийгэм, соёлын өөрчлөлтүүд	r= 0.301-0.700	.662	Эрчимтэй	Салбар дундын зохицуулалтын тойм сургалт (жишээ нь: чиглүүлэх сургалт)
6.2	Эдийн засгийн өөрчлөлтүүд <-> Байгаль орчны өөрчлөлтүүд	r= 0.301-0.700	.604	Эрчимтэй	Салбар дундын зохицуулалтын тойм сургалт (жишээ нь: чиглүүлэх сургалт)
6.3	Эдийн засгийн өөрчлөлтүүд <-> Төр, захиргааны үйл ажиллагааны өөрчлөлтүүд	r= 0.301-0.700	.554	Эрчимтэй	Салбар дундын зохицуулалтын тойм сургалт (жишээ нь: чиглүүлэх сургалт)
6.4	Нийгэм, соёлын өөрчлөлтүүд <-> Байгаль орчны өөрчлөлтүүд	r= 0.301-0.700	.562	Эрчимтэй	Салбар дундын зохицуулалтын тойм сургалт (жишээ нь: чиглүүлэх сургалт)
6.5	Нийгэм, соёлын өөрчлөлтүүд <-> Төр, захиргааны үйл ажиллагааны өөрчлөлтүүд	r= 0.301-0.700	.499	Эрчимтэй	Салбар дундын зохицуулалтын тойм сургалт (жишээ нь: чиглүүлэх сургалт)
6.6	Байгаль орчны өөрчлөлтүүд <-> Төр, захиргааны үйл ажиллагааны өөрчлөлтүүд	r= 0.301-0.700	.581	Эрчимтэй	Салбар дундын зохицуулалтын тойм сургалт (жишээ нь: чиглүүлэх сургалт)



7	Онцлох үзүүлэлт	Хамгийн хүчтэй үзүүлэлт
		Аялал жуулчлал нь түүх, соёлын өвийн мэдлэг, ашиглалтыг сайжруулдаг (3.56) Аялал жуулчлалыг дагаж шинэ мэдлэг, соёлын шинэ хэрэглээ үүсдэг (3.52) Аялал жуулчлал нь орон нутгийн байгалийн үзэмжит газрын нэр хүндийг өсгөдөг (3.49)
		Хамгийн сул үзүүлэлт
		Аялал жуулчлалын улирлаар үйлчилгээний газруудад татвар, торгуулийн дарамт нэмэгддэг (2.69) Аялал жуулчлал нь иргэдийн ахуй, соёлын унаган төрхийг алдагдуулдаг (2.65) Төр, захиргааны бүтэц, хүний нөөцийн өөрчлөлт нь аялал жуулчлалын бодлого, стратегийн хэрэгжилтэд саад учруулдаг (2.56)

4.3 Баянхонгор аймаг

Баянхонгор аймгаас судалгаанд оролцсон 259 иргэдийн эмэгтэй 66.4%, 15-24 насныхан 42.9 %, оюутан, сурагч 39.8 %, аймагтаа 20-с дээш жил амьдарч буй иргэд 39.0 %, эрхэлж буй ажил бизнес нь аялал жуулчлалын үйл ажиллагаатай огт хамааралгүй иргэд 51.4 % тус тус харьцангуй өндөр хувь эзэлж байна.

Иргэдийн өгсөн үнэлгээгээр “Эдийн засгийн өөрчлөлтүүд”-ийн дундаж утга 2.81, «Нийгэм, соёлын өөрчлөлтүүд»-ийн дундаж утга 2.89, «Байгаль орчны өөрчлөлтүүд»-ийн дундаж утга 2.85, «Төр, захиргааны үйл ажиллагааны өөрчлөлтүүд»-ийн дундаж утга 2.60 тус тус гарсан.

Хувьсагчдын эерэг болон сөрөг ойлголтын ялгаатай байдлыг илрүүлэх шинжилгээгээр байгаль орчны ойлголт зөрүү байхгүй үзүүлэлттэй, бусад хувьсагчдын хувьд эерэг ойлголт давамгайлсан үнэлгээтэй байна.


Хувьсагчдын хоорондын хамаарлын шинжилгээгээр бүх хувьсагчид хоорондоо эерэг бөгөөд сайн хамааралтай гэсэн үр дүнтэй гарчээ.

Хамгийн хүчтэй үзүүлэлт «Аялал жуулчлал нь орон нутгийн байгалийн үзэмжит газрын нэр хүндийг өсгөдөг» дундаж утга 3.60, хамгийн сул үзүүлэлт «Аялал жуулчлалыг дагаж авилга, хээл хахуулийн гэмт хэрэг нэмэгддэг» дундаж утга 2.09 тус тус гарсан.

Баянхонгор аймгийн иргэдийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн түншлэлийн зан төлвийн сургалт; үйлчилгээний бизнесийн сургалт; тухайн чиглэлийн суурь мэдлэг олгох сургалт; сөрөг нөлөөллийг тодруулах сургалт; тухайн чиглэлийн тогтвортой байдлын сургалт; салбар

дундын зохицуулалтын болон үнэ цэнийн сүлжээний тойм сургалт зэргийг санал болгосон.

Зураг 4. Баянхонгор аймгийн иргэдийн мэдлэг, ойлголтын ерөнхий үнэлгээ



Хүснэгт 12. ЗӨВЛӨМЖ: Баянхонгор аймаг

№	Зорилго	Үзүүлэлт	Аймгийн үр дүн	Үнэлгээ	Зөвлөмж
1	Тогтвор суурьшил	6-с дээш жил	92.7 %	Уугуул оршин суугч	Үйлчилгээний бизнес эрхлэх хандлагыг өөрчлөх нөлөөллийн сургалт
2	Насны бүлэг	55 хүртэлх	98.5 %	Идэвхтэй	Идэвхтэй арга барилаар мэдлэг дадлыг эзэмшүүлэх (жишээ нь: социал орчин)
3	Бизнесийн уялдаа	Огт хамааралгүй	51.4 %	Огт уялдаагүй	Үйлчилгээний бизнесийн сургалт
		Дам хамааралтай	34.4 %	Уялдаатай	Түншлэлийн зан төлвийн сургалт



4. Мэдлэг ойлголтын түвшин					
4.1	Эдийн засгийн өөрчлөлтүүд	1.67-3.34	2.81	Дундаж мэдлэгтэй	Тухайн чиглэлийн суурь мэдлэг олгох сургалт (жишээ нь: төрөлжсөн сургалт)
4.2	Нийгэм, соёлын өөрчлөлтүүд	1.67-3.34	2.89	Дундаж мэдлэгтэй	Тухайн чиглэлийн суурь мэдлэг олгох сургалт (жишээ нь: төрөлжсөн сургалт)
4.3	Байгаль орчны өөрчлөлтүүд	1.67-3.34	2.85	Дундаж мэдлэгтэй	Тухайн чиглэлийн суурь мэдлэг олгох сургалт (жишээ нь: төрөлжсөн сургалт)
4.4	Төр, захиргааны үйл ажиллагааны өөрчлөлтүүд	1.67-3.34	2.60	Дундаж мэдлэгтэй	Тухайн чиглэлийн суурь мэдлэг олгох сургалт (жишээ нь: төрөлжсөн сургалт)
5. Аялал жуулчлалын нөлөөллийн зэрэг ба сөрөг ойлголтын зөрүү					
5.1	Эдийн засгийн өөрчлөлтүүд	t value +1<	11.894	Эерэг ойлголт давамгайлсан	Тухайн чиглэлийн сөрөг нөлөөллийг тодруулах сургалт (жишээ нь: мониторинг, аудит)
5.2	Нийгэм, соёлын өөрчлөлтүүд	t value +1<	15.549	Эерэг ойлголт давамгайлсан	Тухайн чиглэлийн сөрөг нөлөөллийг тодруулах сургалт (жишээ нь: мониторинг, аудит)
5.3	Байгаль орчны өөрчлөлтүүд	p value p<0.1		Зөрүү байхгүй	Тухайн чиглэлийн тогтвортой байдлын сургалт (жишээ нь: эрсдлийн үнэлгээ)
5.4	Төр, захиргааны үйл ажиллагааны өөрчлөлтүүд	t value +1<	8.253	Эерэг ойлголт давамгайлсан	Тухайн чиглэлийн сөрөг нөлөөллийг тодруулах сургалт (жишээ нь: мониторинг, аудит)
6. Аялал жуулчлалын нөлөөллүүдийн хоорондын хамаарал					
6.1	Эдийн засгийн өөрчлөлтүүд <-> Нийгэм, соёлын өөрчлөлтүүд	r= 0.301-0.700	.677	Эрчимтэй	Салбар дундын зохицуулалтын тойм сургалт (жишээ нь: чиглүүлэх сургалт)
6.2	Эдийн засгийн өөрчлөлтүүд <-> Байгаль орчны өөрчлөлтүүд	r= 0.301-0.700	.643	Эрчимтэй	Салбар дундын зохицуулалтын тойм сургалт (жишээ нь: чиглүүлэх сургалт)

6.3	Эдийн засгийн өөрчлөлтүүд (↔) Төр, захиргааны үйл ажиллагааны өөрчлөлтүүд	$r = 0.301-0.700$.577	Эрчимтэй	Салбар дундын зохицуулалтын тойм сургалт (жишээ нь: чиглүүлэх сургалт)
6.4	Нийгэм, соёлын өөрчлөлтүүд (↔) Байгаль орчны өөрчлөлтүүд	$r = 0.701-1.000$.760	Өндөр эрчимтэй	Салбар дундын үнэ цэнийн сүлжээний тойм сургалт (жишээ нь: чиглүүлэх сургалт)
6.5	Нийгэм, соёлын өөрчлөлтүүд (↔) Төр, захиргааны үйл ажиллагааны өөрчлөлтүүд	$r = 0.301-0.700$.673	Эрчимтэй	Салбар дундын зохицуулалтын тойм сургалт (жишээ нь: чиглүүлэх сургалт)
6.6	Байгаль орчны өөрчлөлтүүд (↔) Төр, захиргааны үйл ажиллагааны өөрчлөлтүүд	$r = 0.701-1.000$.715	Өндөр эрчимтэй	Салбар дундын үнэ цэнийн сүлжээний тойм сургалт (жишээ нь: чиглүүлэх сургалт)
7	Онцлох үзүүлэлт	Хамгийн хүчтэй үзүүлэлт			
		Аялал жуулчлал нь орон нутгийн байгалийн үзэмжит газрын нэр хүндийг өсгөдөг (3.6) Аялал жуулчлал нь түүх, соёлын өвийн мэдлэг, ашиглалтыг сайжруулдаг (3.52) Аялал жуулчлал нь орон нутгийн худалдаа, үйлчилгээг идэвхжүүлдэг (3.42)			
		Хамгийн сул үзүүлэлт			
		Аялал жуулчлал нь иргэдийн амар тайван байдлыг алдагдуулдаг (2.18) Аялал жуулчлалыг хөгжүүлснээр ХАА-н (газар тариалан, мал аж ахуй) ажиллах хүчний хомсдол үүсдэг (2.12) Аялал жуулчлалыг дагаж авилга, хээл хахуулийн гэмт хэрэг нэмэгддэг (2.09)			



4.4 Булган аймаг

Булган аймгаас судалгаанд оролцсон 600 иргэдийн эмэгтэй 55.1 %, 35-44 насныхан 31.7 %, төрийн албан хаагч 46.7 %, аймагтаа 20-с дээш жил амьдарч буй иргэд 38.3 %, эрхэлж буй ажил бизнес нь аялал жуулчлалын үйл ажиллагаатай дам хамааралтай иргэд 45.5 % тус тус харьцангуй өндөр хувь эзэлж байна.

Иргэдийн өгсөн үнэлгээгээр “Эдийн засгийн өөрчлөлтүүд”-ийн дундаж утга 3.14, «Нийгэм, соёлын өөрчлөлтүүд»-ийн дундаж утга 3.26, «Байгаль орчны өөрчлөлтүүд»-ийн дундаж утга 3.29, «Төр, захиргааны үйл ажиллагааны өөрчлөлтүүд»-ийн дундаж утга 2.76 тус тус гарсан.


Хувьсагчдын эерэг болон сөрөг ойлголтын ялгаатай байдлыг илрүүлэх шинжилгээгээр байгаль орчны эерэг ойлголт сөргөөсөө бага үзүүлэлттэй, бусад хувьсагчдын хувьд эерэг ойлголт давамгайлсан үнэлгээтэй байна.

Хувьсагчдын хоорондын хамаарлын шинжилгээгээр бүх хувьсагчид хоорондоо эерэг бөгөөд сайн хамааралтай гэсэн үр дүнтэй гарчээ.

Хамгийн хүчтэй үзүүлэлт «Аялал жуулчлалыг дагаж хуванцар болон нийлэг материалын хэрэглээ өсдөг» дундаж утга 4.13, хамгийн сул үзүүлэлт «Аялал жуулчлалыг дагаж авилга, хээл хахуулийн гэмт хэрэг нэмэгддэг» дундаж утга 2.20 тус тус гарсан.

Булган аймгийн иргэдийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйлчилгээний бизнесийн сургалт; түншлэлийн зан төлвийн сургалт; тухайн чиглэлийн суурь мэдлэг олгох сургалт; сөрөг нөлөөллийг тодруулах сургалт; эерэг хандлага, мэдлэг чадварын манлайлалын сургалт; салбар дундын зохицуулалтын болон үнэ цэнийн сүлжээний тойм сургалт зэргийг санал болгосон.

Зураг 5. Булган аймгийн иргэдийн мэдлэг, ойлголтын ерөнхий үнэлгээ



Хүснэгт 13. ЗӨВЛӨМЖ: Булган аймаг

№	Зорилго	Үзүүлэлт	Аймгийн үр дүн	Үнэлгээ	Зөвлөмж
1	Тогтвор суурьшил	6-с дээш жил	91.0 %	Уугуул оршин суугч	Үйлчилгээний бизнес эрхлэх хандлагыг өөрчлөх нөлөөллийн сургалт
2	Насны бүлэг	55 хүртэлх	88.6 %	Идэвхтэй	Идэвхтэй арга барилаар мэдлэг дадлыг эзэмшүүлэх (жишээ нь: социал орчин)
3	Бизнесийн уялдаа	Огт хамааралгүй	35.3 %	Огт уялдаагүй	Үйлчилгээний бизнесийн сургалт
		Шууд хамааралтай	45.5 %	Уялдаатай	Түншлэлийн зан төлвийн сургалт
4. Мэдлэг ойлголтын түвшин					
4.1	Эдийн засгийн өөрчлөлтүүд	1.67-3.34	3.14	Дундаж мэдлэгтэй	Тухайн чиглэлийн суурь мэдлэг олгох сургалт (жишээ нь: төрөлжсөн сургалт)
4.2	Нийгэм, соёлын өөрчлөлтүүд	1.67-3.34	3.26	Дундаж мэдлэгтэй	Тухайн чиглэлийн суурь мэдлэг олгох сургалт (жишээ нь: төрөлжсөн сургалт)



4.3	Байгаль орчны өөрчлөлтүүд	1.67-3.34	3.29	Дундаж мэдлэгтэй	Тухайн чиглэлийн суурь мэдлэг олгох сургалт (жишээ нь: төрөлжсөн сургалт)
4.4	Төр, захиргааны үйл ажиллагааны өөрчлөлтүүд	1.67-3.34	2.76	Дундаж мэдлэгтэй	Тухайн чиглэлийн суурь мэдлэг олгох сургалт (жишээ нь: төрөлжсөн сургалт)
5. Аялал жуулчлалын нөлөөллийн эерэг ба сөрөг ойлголтын зөрүү					
5.1	Эдийн засгийн өөрчлөлтүүд	t value +1<	9.647	Эерэг ойлголт давамгайлсан	Тухайн чиглэлийн сөрөг нөлөөллийг тодруулах сургалт (жишээ нь: мониторинг, аудит)
5.2	Нийгэм, соёлын өөрчлөлтүүд	t value +1<	6.818	Эерэг ойлголт давамгайлсан	Тухайн чиглэлийн сөрөг нөлөөллийг тодруулах сургалт (жишээ нь: мониторинг, аудит)
5.3	Байгаль орчны өөрчлөлтүүд	t value -1<	-9.535	Сөрөг ойлголт давамгайлсан	Тухайн чиглэлийн эерэг хандлага, мэдлэг чадварын манлайлалын сургалт (жишээ нь: шилдэг туршлага)
5.4	Төр, захиргааны үйл ажиллагааны өөрчлөлтүүд	t value +1<	2.519	Эерэг ойлголт давамгайлсан	Тухайн чиглэлийн сөрөг нөлөөллийг тодруулах сургалт (жишээ нь: мониторинг, аудит)
6. Аялал жуулчлалын нөлөөллүүдийн хоорондын хамаарал					
6.1	Эдийн засгийн өөрчлөлтүүд <-> Нийгэм, соёлын өөрчлөлтүүд	r= 0.701-1.000	.743	Өндөр эрчимтэй	Салбар дундын үнэ цэнийн сүлжээний тойм сургалт (жишээ нь: чиглүүлэх сургалт)
6.2	Эдийн засгийн өөрчлөлтүүд <-> Байгаль орчны өөрчлөлтүүд	r= 0.301-0.700	.620	Эрчимтэй	Салбар дундын зохицуулалтын тойм сургалт (жишээ нь: чиглүүлэх сургалт)
6.3	Эдийн засгийн өөрчлөлтүүд <-> Төр, захиргааны үйл ажиллагааны өөрчлөлтүүд	r= 0.301-0.700	.569	Эрчимтэй	Салбар дундын зохицуулалтын тойм сургалт (жишээ нь: чиглүүлэх сургалт)

6.4	Нийгэм, соёлын өөрчлөлтүүд (↔) Байгаль орчны өөрчлөлтүүд	$r = 0.301-0.700$.641	Эрчимтэй	Салбар дундын зохицуулалтын тойм сургалт (жишээ нь: чиглүүлэх сургалт)
6.5	Нийгэм, соёлын өөрчлөлтүүд (↔) Төр, захиргааны үйл ажиллагааны өөрчлөлтүүд	$r = 0.301-0.700$.542	Эрчимтэй	Салбар дундын зохицуулалтын тойм сургалт (жишээ нь: чиглүүлэх сургалт)
6.6	Байгаль орчны өөрчлөлтүүд (↔) Төр, захиргааны үйл ажиллагааны өөрчлөлтүүд	$r = 0.301-0.700$.631	Эрчимтэй	Салбар дундын зохицуулалтын тойм сургалт (жишээ нь: чиглүүлэх сургалт)
7	Онцлох үзүүлэлт	Хамгийн хүчтэй үзүүлэлт			
		Аялал жуулчлалыг дагаж хуванцар болон нийлэг материалын хэрэглээ өсдөг (4.13) Аялал жуулчлал нь хог хаягдлыг нэмэгдүүлдэг (3.96) Аялал жуулчлал нь орон нутгийн байгалийн үзэмжит газрын нэр хүндийг өсгөдөг (3.93)			
		Хамгийн сул үзүүлэлт			
		Аялал жуулчлалыг дагаж зэрлэг ан амьтан болон ургамал хамгаалал, бүртгэлжүүлэлт сайжирдаг (2.38) Аялал жуулчлалыг хөгжүүлснээр ХАА-н (газар тариалан, мал аж ахуй) ажиллах хүчний хомсдол үүсдэг (2.36) Аялал жуулчлалыг дагаж авилга, хээл хахуулийн гэмт хэрэг нэмэгддэг (2.20)			

4.5 Говь-Алтай аймаг

